



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 04 сар | Дугаар 17

ГАРЧИГ

- 2-3** Бодлогын нийтлэл
- 3-4** Зохицуулалтын мэдээ
- 6-7** Коронавирусын тархалт нь биднийг санхүүгийн хувьд илүү сахилга баттай, дархлаатай байх ёстойг сануулсан сургамж болж байна
- 7-8** Тайлбар ба зөвлөмж
- 9-10** Финтекийн салбар дахь онцлох мэдээллүүд
- 11-14** Судлаачийн индэр
- 14-16** Зээлийн батлан даалтын сан
- 16-17** Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн ажлын хэсгийн цахим уулзалт
- 17** Иргэдийн санхүүгий боловсролд зориулж теле хичээл
- 18-19** Комплайнсын хяналтын онцлог ба ялгаа
- 19-22** Зах зээлийн мэдээ
- 23** Олон улсын зах зээлийн мэдээ
- 24** Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс



КОРОНАВИРУСЫН ТАРХАЛТ НЬ БИДНИЙГ САНХҮҮГИЙН ХУВЬД ИЛҮҮ САХИЛГА БАТТАЙ, ДАРХЛААТАЙ БАЙХ ЁСТОЙГ САНУУЛСАН СУРГАМЖ БОЛЖ БАЙНА

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ удаагийн байр суурь булангаар СЗХ-ны орон тооны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулуун ярилцлага өглөө.

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе. Дэлхий нийтээр тархаад буй шинэ төрлийн корона вирусны өвчлөлөөс шалтгаалан эдийн засаг, санхүүгийн зах зээлд ямар эрсдэл тулгараад байна вэ? нөхцөл байдал ямар байна вэ? гэсэн асуултаас энэ удаагийн ярилцлагаа эхлэе.

Сайн байна уу? Юуны өмнө Хүртээмжтэй санхүү сэтгүүлийн уншигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2020 он гараад 4 сарын хугацаа өнгөрч, уг хугацаанд корона вирусны өвчлөлийн улмаас бидний өдөр тутмын амьдрал, бизнесийн орчин, цаашлаад санхүүгийн зах зээл, эдийн засагт өмнө нь төсөөлж байгаагүй өөрчлөлтүүд тохиож байна. Оны эхээр тархаж эхэлсэн корона вирусны халдвар 100 хүрэхгүй хоногийн дотор л дэлхий даяар тархаж, олон мянган хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл үүсгэн, дэлхий нийтийг хамарсан хөл хориог тогтоосон цар тахал болж даамжирсан. Халдварт өвчний тархалтыг тогтоон барихын тулд хөл хорио тогтоох нь хамгийн зөв бөгөөд үр дүнтэй хэрэгсэл байсан хэдий ч хөл хорионы хязгаарлалт удах тусам бодлого гаргагчид иргэдийн амь нас болон амьдралын чанарыг хадгалах гэсэн 2 чухал шаардлагатай нүүр тулаад байна.

Мэдээж нийгмийн амьдрал өөрөө хүнээс бүрдэж, эдийн засаг, зах зээл хүний үйл хөдлөл, шийдвэр гаргалтан дээр суурилан ажиллаж байдаг учраас дэлхийн хэмжээг хамарсан энэ өвчлөл, хорио цээр бүхий л улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх нь тодорхой. ОУВС-ын шинжээчдийн хамгийн сүүлийн тооцооллоор гэхэд дэлхийн эдийн засаг 2020 онд 3.0 хувиар агших төлөвтэй бөгөөд энэ нь 1930-аад оны их хямрал, 2008 оны санхүүгийн хямрал зэрэг томоохон хямралуудаас ч илүү хор уршиг дагуулах тухай эдийн засагч, судлаачид байр сууриа илэрхийлсээр байна. Хэдийгээр хөгжиж буй улс орнууд тэр дундаа Азийн орнуудын хувьд бууралт хамгийн бага байхаар төсөөлөл гарч байгаа ч гэсэн сүүлийн 60 жилийн туршид ажиглагдаагүй уналт, агшилт тохиож байгаа юм. Энэхүү тооцоолол нь мэдээж халдварт өвчлөлийн тархалт, хорио цээр хэр удаан үргэлжлэхээс шалтгаалаад илүү муудаж ч болзошгүй. Цаашлаад хэдий хугацааны хорио цээрийг эдийн засаг, зах зээл маань давж гарч чадах вэ? халдварт өвчний тархалт багассаны дараагаар хэрхэн эдийн засаг, зах зээлээ дахин өндөр эрсдэл үүсгэхгүйгээр сэргээх вэ? зэрэг чухал асуудлууд бидний өмнө гарч ирээд байна.

Үргэлжлэл 6-р нүүрт >>

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙ БОЛОВСРОЛД ЗОРИУЛЖ ТЕЛЕ ХИЧЭЭЛ ЯВУУЛЖ БАЙНА

Санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, Боловсрол,соёл, шинжлэх ухаан спортын яам /БСШУСЯ/, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг 2016 оноос хэрэгжүүлж байгаа билээ. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих боломжтой болно.



Үргэлжлэл 17-р нүүрт >>

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- +976-51-264444
- press@frc.mn
- www.frc.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ НИЙТЛЭЛ

Манай улсын хувьд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн шатанд төрөөс өмч хувьчлалыг хөрөнгийн зах зээлээр дамжуулан хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн нь хөрөнгийн зах зээл үүсэх үндсэн нөхцөл болсон. Монгол Улсын Их Хурлаас дээрх харилцааг зохицуулах үүднээс Үнэт цаасны тухай анхны хуулийг 1994 онд баталж, хуулийн хүрээнд үнэт цаасны зах зээлд хяналт тавих, төрийн зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч Үнэт цаасны хороо байгуулагдсан билээ.

Улмаар аж ахуйн нэгжүүд дан ганц банкны зээлийн санхүүжилтээс гадна хувьцаа, бонд гаргах замаар нээлттэй хүрээнд арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг татах нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд оролцогчид болох брокер, дилер, андеррайтер, дэд бүтцийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, тэдгээрийн уялдааг хангах, төрийн зохицуулагч байгууллагаас тавих хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс УИХ-аас 2002 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн баталсан.

2002 оны Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь 10 гаруй жилийн хугацаанд зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх чиглэлд тодорхой ахиц, дэвшлийг бий болгож байсан хэдий ч цаашид үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, өсөлтийг нэмэгдүүлэхэд олон улсын туршлагыг нэвтрүүлэх, бүс нутгийн интеграцад нэгдэн орох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах шаардлага тулгарсан.

Тиймээс Улсын Их Хурлаас 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд дээрх хуулийн шинэчилсэн найруулга нь олон улсын стандартад нийцсэн, тэдгээрт хэрэглэгддэг нийтлэг зохицуулалтыг

агуулснаар онцлог болсон. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар кастодиан банкны үйлчилгээ, давхар бүртгэл, хадгаламжийн бичиг, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал, өөрийгөө зохицуулах байгууллага, зах зээлийг урвуулан ашиглахаас хамгаалах, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохоос урьдчилан сэргийлэх зэрэг шинэ зохицуулалтууд орсон бөгөөд 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Мөн Улсын Их Хурлаас 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулийн хэрэгжилт 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлсэн. Дээрх Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэх байгуулах, сангийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдуулан хөрөнгө оруулалтын менежментийн компанид тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зэрэг харилцааг зохицуулсан.

Хэдийгээр үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчин сайжирч байгаа хэдий ч, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны арилжаа зэрэг хөгжлийн ерөнхий үзүүлэлтүүд бусад орнуудтай харьцуулахад хангалтгүй, олон улсад нийтлэг хэрэглэгдэж хүлээн зөвшөөрсөн төлбөр тооцоо, өмчлөх эрхийн бүртгэлийн зарим стандарт нэвтрээгүй, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ ялангуяа санхүүгийн шинэ технологид түшиглэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхэд хязгаарлагдмал, олон нийтэд үнэт цаас гаргах ажиллагааг хэт чирэгдэлтэй байдлаар зохицуулж, өөрийгөө зохицуулах байгууллагуудын чиг үүргийн ялгаа, заагийг нарийвчлан тодорхойлж чадаагүй. Тиймээс зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд, оролцогчдын зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулах, зохицуулалтгүй үлдсэн зарим харилцааг эрх

зүйн орчноор бий болгох шаардлагыг төрийн зохицуулагч байгууллагад тавьсан.

Иймд Хорооны зүгээс Хөрөнгийн зах зээл дэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулагдах нөхцөлийг сайжруулах зэрэг цаг үеийн шинж чанартай асуудлууд тулгарч байгаатай холбогдуулан хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчинг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах саналыг хүргүүлж, УИХ-аар батлуулсан.

Мөн Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн Хөрөнгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчныг шинэчилж, зохицуулагч байгууллагын зохицуулалт, хяналтын чадавхыг сайжруулж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгын 2.1.1-д “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг сайжруулах, шинэ эрх зүйн зохицуулалтыг бий болгох” гэж тусгагдсан байдаг.

Улмаар Сангийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 227 дугаар тушаалаар “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг Хороо, дэд бүтцийн байгууллага, мэргэжлийн оролцогч байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулсан бөгөөд Хорооны зүгээс хуулийн төсөлд эхний байдлаар бодлогын хүрээнд дараах холбогдох өөрчлөлтүүдийг оруулахаар төслийг боловсруулаад байна. Үүнд:

- Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагатай зарчмын саналуудыг тусгаж, зохицуулалттай зах зээл, биржийн бус зах зээл, төлбөр, тооцоо, мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт болон шинээр биржийн зах зээл, клирингийн үйл ажиллагаа, хамтын санхүүжилттэй холбоотой өөрчлөлт;

- Мөн компаниуд олон нийтэд үнэт цаасаа санал болгох ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр, Хорооны бүртгэл /registration rule/ арилжаа эрхлэх байгууллагын бүртгэл /listing rule/-ийн хоорондын ялгааг нарийвчлан тодорхойлж, бүртгэлийн давхардлыг арилгах, үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгох нь хугацаа их шаардагдах, зардал, өртөг нэмэгдэх зэрэг хүндрэлтэй байдлыг бий болгож байгаа тул үнэт цаасны анхдагч зах зээл, хоёрдогч зах зээл дээр арилжаа нээх зөвшөөрөл олгодог зохицуулалтыг хасах замаар үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах;

- Хороо болон Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага “ЖАЙКА”-тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл”-ийн зөвлөхөөс компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх, биржийн бус зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой зөвлөмжийг өгсөн. Үүний хүрээнд компани нээлттэй өрийн хэрэгсэл гаргах замаар санхүүжилт татахтай холбоотойгоор үүсч буй зардал, хугацаа, бонд гаргахад тавигдах нөхцөл, шаардлага болон зохицуулалтын зарим давхардлыг арилгах, тавигдаж буй шаардлага, нөхцөлийг багасгах, биржийн бус зах зээлийн эрх зүйн зохицуулалтын орчныг сайжруулах;

- Хороо болон өөрийгөө зохицуулах байгууллагын хоорондын чиг үүргийн давхардлыг арилгах, өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагааг дэмжих, чиг үүрэг, хариуцлагын тогтолцоог сайжруулах хүрээнд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрх олгох сургалтыг зохион байгуулах, өөрийн журмаар сургалттай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулах;

- Мөн санхүүгийн шинэ технологид түшиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр биржийн бус зах зээл дээр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч болон гарааны бизнес эрхлэгчид бизнесийн төсөл, хөтөлбөрөө тусгайлсан цахим платформоор дамжуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагад танилцуулан хөрөнгө оруулалт татах ажиллагааг бий болгох хүрээнд хамтын санхүүжилтийн зохицуулалтыг шинээр тодорхойлсон.

Дээрх нэмэлт, өөрчлөлтийн саналуудыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөлд оруулснаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, улмаар үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварын түвшинг дээшлүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог өсгөж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх зэрэг үр дүнгүүдийг авчрахад чухал шаардлагатай гэж үзэж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн эцсийн хувилбар, хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох судалгаа, практик шаардлагын талаарх танилцуулгыг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу олон нийтээс санал авч, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулахаар ажлын хэсгийн зүгээс ажиллаж байна.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТАНИЛЦУУЛАА



Санхүүгийн зохицуулах хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн хэрэгжилт болон үйл ажиллагааны тайлангаа жил тутам Улсын Их Хуралд тайлагнадаг билээ.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ.

Хуралдаанд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, бичил санхүүгийн салбарын 2019 оны гол үзүүлэлтүүд, тэдгээрийн өөрчлөлт, зохицуулалт, хяналтын чиглэлээр хийгдсэн арга хэмжээ, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулав. Мөн 2020 онд хэрэгжүүлж эхлээд буй томоохон арга хэмжээнүүд болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй гол ажлуудынхаа талаар мэдээллээ.

Танилцуулгатай холбогдуулан УИХ-ын гишүүд хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүслийг хэрхэн хянаж байгаа, зээлийн үйлчилгээний өртгийг бууруулах, санхүүгийн хэрэглэгч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах замаар мөнгө хүүлэлтийн эсрэг болон санхүүгийн бус мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бий болгох, зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт шалгалт хийх үйл ажиллагаандаа техник, технологи ашиглах зэрэгтэй холбоотой асуудлуудыг хөндөж, санал солилцов.

Түүнчлэн зарим гишүүд олон жилийн хугацаанд шийдэгдээгүй байсан хөрөнгийн зах зээлийн арилжааны төлбөр тооцооны Т+2 шинэ горимд шилжсэн болон корона вирус /КОВИД-19/-ын нөхцөл байдалтай уялдуулан холбогдох арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлэн ажиллаж байгааг сайшаан дэмжлээ.

ҮНЭТ ЦААСНЫ ДАРАА ТӨЛБӨР ТООЦОНЫ ШИНЭ ГОРИМД ШИЛЖЛЭЭ

Хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгын хүрээнд олон жил яригдаж, бодит ажил хэрэг болоогүй байсан үнэт цаасны дараа төлбөр тооцооны горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэхэд Санхүүгийн зохицуулах хороо онцгой анхаарал хандуулан ажиллаж, 2020 оны нэгдүгээр сарын 29-ний өдөр үнэт цаасны дараа төлбөр тооцооны горимыг нэвтрүүлэх тухай бодлогын томоохон шийдвэр гаргасан.

Монгол Улсын хөрөнгийн зах зээл цаашид хөгжих асар их боломжтой зах зээл гэж гадна, дотны санхүүчид, эдийн засагчид үздэг. Гэтэл хөгжилд саад болж буй суурь хүчин зүйлс маш их байдаг.

Эдгээрийн нэг нь үнэт цаасны төлбөр тооцооны горимтой холбоотой асуудал гэдгийг зах зээлд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагууд, үйлчилгээ үзүүлдэг дэд бүтцийн байгууллагууд болон бодлого боловсруулагч нар тодорхойлоод олон жил болж байна. Гэвч арилжаанд оролцох хөрөнгө оруулагч өөрийн арилжааны захиалга биелэх эсэхээс үл хамааран захиалга өгөхөөс өмнө үнэт цаасны төлбөрийг 100 хувь байршуулдаг төлбөр тооцооны горимыг манай улс өөрчилж чадалгүй өнөөг хүрсэн байна.

Хорооноос гаргасан шийдвэрийн дагуу дараа төлбөр тооцооны горимыг нэвтрүүлэх бэлтгэл ажлуудыг хангасны үндсэн дээр энэ оны гуравдугаар сарын 31-ний өдрөөс хэрэгжүүлж эхэллээ. Ингэснээр үнэт цаасны компаниудыг санхүү, хүний нөөц, програм хангамжийн чадавх дээр нь тулгуурлан клирингийн гишүүнчлэлээр элсүүлсэн. Эдгээр гишүүнчлэлтэй үнэт цаасны компаниар дамжуулан хөрөнгө оруулагчид захиалга өгч буй дүнгийнхээ 30 хүртэл бууруулсан дүнгээр барьцаа байршуулан үнэт цаасны захиалга өгч арилжаанд оролцох нөхцөл бүрдэнэ. Гэхдээ байршуулах барьцааг 30 хувь хүртэл бууруулах уу, 100 хувь хэвээр байлгах уу, эсвэл энэ хоёрын дунд тодорхой хувиар тогтоох уу гэдгийг үнэт цаасны компаниуд тухайн харилцагчийн эрсдэлийг үнэлсний үндсэн дээр харилцагч тус бүрээр тогтооно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНД ШИЛЖЛЭЭ



Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй “Дижитал шилжилт” хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулах бодлого, стратегийг боловсруулж, шат дараалсан арга

хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Санхүүгийн зохицуулах хороо энэ ажилд өндөр ач холбогдол өгч, манлайлан хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг хялбаршуулах, иргэд үйлчлүүлэгчдэд шуурхай хүргэх, үйлчилгээний ил тод байдлыг хангах, улмаар төрийн үйлчилгээн дэх хүнд суртлыг арилгах, төвлөрлийг сааруулах зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор цахимаар өргөдөл, гомдол хүлээн авах болон “Зөвшөөрлийн цахим систем”-ийг нэвтрүүллээ.

Эдгээр системүүдээр иргэн, хуулийн этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд онлайн хэлбэрээр санхүүгийн байгууллагуудтай холбоотой өргөдөл, гомдол гаргах, тусгай зөвшөөрлийн хүсэлтээ мэдүүлэх, бусад зөвшөөрөл хүсэх, бүртгэл хийлгэх баримт бичгээ илгээж шийдвэрлүүлэх боломжтойн зэрэгцээ эдгээр өргөдөл, гомдол, хүсэлтийнхээ хяналтын шатны үйл явцыг хянах боломжтой юм.

Энэхүү системүүд нь өнөөдөр нийгэмд тулгараад буй шинэ төрлийн коронавируст (КОВИД-19) цар тахлын тархалттай холбоотойгоор үүсээд буй хорио цээрийн дэглэмийн үед ач холбогдолтой ажил боллоо.

Мөн цаг үеийн хорио цээрийн нөхцөл байдалтай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаан болон бусад уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна.

“Зөвшөөрлийн цахим систем”-ийг нэвтрүүлснээр тус Хорооны зохицуулалтад хамаарах бүхий л этгээд системд бүрэн хамрагдан бүх төрлийн зөвшөөрөл авах хүсэлтээ цахимаар ирүүлж, шийдвэрлүүлэх боломжтой болж байгаа бөгөөд мөн Хорооны зохицуулалтад шинээр нэмэгдсэн үнэт металл, үнэт чулууны, эсвэл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэгчдэд тусгай зөвшөөрлийг олгох цэсийг системд нэмж байршуулж, хүсэлтийг хүлээн авч эхлээд байна.

ГАДААДАД ЗОРЧИГЧДЫН ДААТГАЛ БА КОВИД-19

Монгол улсын даатгалын зах зээлд нийт 12 даатгалын компани гадаадад зорчигчийн гэнэтийн ослын болон аяллын даатгалын бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсний үндсэн дээр худалдан борлуулж байна.

Эдгээр бүтээгдэхүүний хүрээнд даатгалын хамгаалалт нь даатгалын компани бүрийн бүтээгдэхүүний онцлогоос хамаарах бөгөөд нийтлэг байдлаар даатгуулагчийн гадаад улсад зорчин явах үедээ гэнэт өвдсөн болон гэнэтийн осолд орж эмчлүүлэхэд гарсан эмчилгээний зардал, эмнэлгийн байгууллагын хяналтад нүүлгэн шилжүүлэх зардал, нислэг хойшлогдсон, ачаа тээш хоцорсны зардал, ачаа тээш болон хувийн эд зүйлс алдагдах зэрэг эрсдэлүүд хамаарна.



Иймээс Монгол Улсаас гадаад орон руу аялал жуулчлал, бизнес уулзалт, хурал зөвлөгөөнд оролцохоор зорчин явж буй иргэн таны амь нас, эрүүл мэндэд гэнэтийн санаандгүй хохирол учрах, захиалсан хуваарьт нислэг

хойшилсноос үүдэн гарах хохирол, түүнчлэн ачаа тээш, хувийн эд зүйлс, бичиг баримт алдагдсан зэрэг тохиолдолд даатгалын гэрээний нарийвчилсан заалтууд, даатгалын нөхөн төлбөр олгох болон олгохгүй нөхцөлүүдийг дахин сайтар нягтлан үзэхийг зөвлөж байна.

Даатгуулагч та дээрх нөхцөл бэрхшээлтэй тулгарсан үед дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээрэй. Үүнд:

- Даатгалын гэрээгээ сайтар судлан, танд учирсан эрсдэл даатгалын гэрээгээр хамгаалагдах эсэхээ тодруулж харах;
- Даатгалын тохиолдлын талаар даатгалын компанидаа нэн даруй мэдэгдэх;
- Даатгалын тохиолдол буюу учирсан нөхцөл байдалтай холбоотой бүрдүүлбэл зохих баримт бичгийг гэрээнд заасан хугацаанд түргэн шуурхай гаргаж өгөх зэрэг болно. Ингэснээр даатгалын компаниас танд олгох нөхөн төлбөрийг шийдвэрлэх хугацааг богиносгох боломжтой юм.

Олон улсад үүсээд буй КОВИД-19-ийн хорио цээр тогтоосон хугацааны өмнө эсхүл дараа нь аялал эхэлсэн эсэхээ зарим даатгалын гэрээний хамгаалалт хамаарч болохыг даатгуулагч та бүхэн анхаарна уу.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО “КОВИД-19 АМЬ НАС, ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН ДААТГАЛ”-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ШУУРХАЙ БҮРТГЭЖ АЖИЛЛАЛАА



Дэлхий даяар өргөн хүрээнд тархаж буй шинэ коронавируст (КОВИД-19) халдвар нь цар тахлын хэмжээнд хүрч, өнөөдрийн байдлаар 209 улсад тархсан байна. Монгол Улсад “КОВИД-19” халдварын анхны тохиолдол 2020.03.10-ны өдөр бүртгэгдсэн бөгөөд, дээрх өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, вирусийн тархалтыг тогтоон барих хүрээнд Монгол Улсын Засгийн газар Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин, шаардлагатай бүхий л арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байна.

Энэ хүнд үед “Нэйшнл лайф даатгал” ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд халдварын өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй улсын эмнэлгийн ажилтнууд, онцгой байдлын албан хаагчид болон төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүйгээр даатгах “КОВИД-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”-ын бүтээгдэхүүнийг боловсруулан ирүүлсэн.

Хорооны зүгээс цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан түргэн шуурхай ажиллаж, вирусийн тархалтыг тогтоон барихаар өвчний голомт дээр ажиллаж буй төрийн албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүй даатгаж байгааг дэмжиж, Хорооны хуралдаанаар хэлэлцэн “КОВИД-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”-ын бүтээгдэхүүнийг бүртгэлээ.

“КОВИД-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”-д Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 13.1.6-д заасан төрийн тусгай албан хаагчид, Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.5-д заасан эмнэлгийн мэргэжилтнүүд, мөн хуулийн 3.1.6-д заасан эрүүл мэндийн нийт ажилтнууд үнэ төлбөргүй хамрагдах боломжтой.



БАЙР СУУРЬ

» Эхлэл 1-р нүүрт

КОРОНАВИРУСЫН ТАРХАЛТ НЬ БИДНИЙГ САНХҮҮГИЙН ХУВЬД ИЛҮҮ САХИЛГА БАТТАЙ, ДАРХЛААТАЙ БАЙХ ЁСТОЙГ САНУУЛСАН СУРГАМЖ БОЛЖ БАЙНА

“ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ” СЭТГҮҮЛИЙН ЭНЭ УДААГИЙН БАЙР СУУРЬ БУЛАНГААР СЗХ–НЫ ОРОН ТООНЫ ГИШҮҮН, ДЭД ДАРГАН ХҮДЭРЧУЛУУН ЯРИЛЦЛАГА ӨГЛӨӨ.

Энэ үүсээд буй нөхцөл байдал манай улсын санхүүгийн зах зээлд ямар нөлөө үзүүлж байна вэ? цаашид хэр их эрсдэл учрахаар хүлээгдэж байна вэ?

Бизнесийн бүхий л салбаруудын адилаар санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулагчдын үйл ажиллагаа тасалдан, орлого буурах, ажлын байраа хадгалж үлдэхэд хүндрэл учрах зэрэг томоохон эрсдэлүүд үүсээд байна. Гэхдээ санхүүгийн салбар өөрөө эдийн засаг, зах зээлийн үйл ажиллагааны эрсдэл, тодорхой бус байдлыг хамгийн түрүүнд мэдэрдэг, термометрийн үүргийг гүйцэтгэгч нь байдаг.

Тухайлбал шинэ төрлийн корона вирус тархаж эхлэн улс орнуудын эдийн засаг удаашран, үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа зогсоож эхэлж байхад олон улсын хөрөнгийн зах зээл дээрх томоохон индексүүд 2008 оны санхүүгийн хямралаас хойш тохиогоогүй хамгийн муу үзүүлэлтүүдээ үзүүлж байсан. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хувьд харьцангуй жижиг, хувьцааны төвлөрөл өндөр, хөрвөх чадвар сул байдаг зэргээс шалтгаалан бусад зах зээлүүдийн адилаар савлах эрсдэл нь харьцангуй бага байгаа юм. Гэхдээ эдийн засаг, бизнесийн салбаруудад тодорхой бус байдал үүсэж, ашиг орлого нь буурч байгаа учраас хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, топ 20 индекс сүүлийн сард бууралттай байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд зээлийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг. Тийм учраас зээлийн чанар муудах гэсэн хамгийн том эрсдэл үүсэж байна. Хадгаламж, зээлийн хоршоодын хувьд ч мөн адил зээлийн чанар муудах, цаашлаад гишүүд нь хадгаламжаа татах зэрэг томоохон эрсдэл байгаа хэдий ч хадгаламж, зээлийн хоршоод нь зөвхөн гишүүддээ үйл ажиллагаа явуулдаг ашиг олох зорилготой бизнес

эрхлэгчээс илүүтэйгээр гишүүдийнхээ санхүүгийн хэрэгцээг хангах зорилготой коммунити бүлэг учир одоогоор хөрөнгийн чанар, хүрэлцээ нь алдагдах эрсдэл үүсээгүй.

Даатгалын зах зээлийн хувьд ч гэсэн хорио цээрийн улмаас хураамжийн орлого буурах, аялал, жуулчлал, бизнесийн эрсдэлийн даатгал зэрэг тодорхой төрлийн даатгалын бүтээгдэхүүнүүдийн хувьд өндөр эрсдэл үүсэх төлөвтэй байна.

Гэхдээ санхүүгийн салбар, мэргэжлийн оролцогчид, тэдгээрийн үйл ажиллагааны хувьд нөхцөл байдал харьцангуй тогтвортой байгаа буюу их хэмжээний эрсдэл үүсээгүй байгаа гэдгийг хэрэглэгчиддээ сануулах нь зүйтэй болов уу. Үүнд мэдээж зах зээлд оролцогчид маань бизнесийн үйл ажиллагаагаа тасалдуулалгүй, төрийн эрх бүхий байгууллагуудаас гаргасан зөвлөмж, чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэн, нийгмийн хариуцлагаа ухамсарлан хямралыг хамтдаа даван гарахын төлөө хүчин чармайлт гарган ажиллаж байгаа нь нөлөөлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

Бидний хувьд халдвар анх БНХАУ–д эрчимтэй тархаж эхэлсэн 1 дүгээр сарын дунд үеэс эхлэн корона вирусын өөрчлөлтийн улмаас эдийн засаг, санхүүгийн зах зээлд үүсээд буй нөхцөл байдал, олон улсад хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тогтмол мэдээлэл цуглуулан Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг, Олон Улсын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо зэрэг хамтран ажилладаг олон улсын байгууллагуудтай цахим хуралдаан, семинарыг зохион байгуулан туршлага солилцох, асуулгын аргаар зах зээлд оролцогчдын үйл ажиллагааны тасралтгүй байдлын талаар мэдээлэл цуглуулан холбогдох зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн, зохицуулагч байгууллагаас

төвлөрүүлдэг шимтгэл, хураамжийн хугацааг хойшлуулан ажиллаж байна.

Одоогийн байдлаар бид гэнэтийн эрсдэл, хямрал тохиосон онцгой нөхцөл байдал үүссэн үед санхүүгийн салбарт баримтлах бэлэн байдлын стратеги, төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна. Аливаа хямрал, онцгой нөхцөл байдал үүсэхэд түүнийг давж гарах, үйл ажиллагааныхаа тасралтгүй байдлыг хангах, хямралыг аль болох хохирол багатайгаар гарахад бэлтгэлтэй байхаас гадна онцгой нөхцөл байдал нэгэнт тохиосон үед ухаалаг шийдвэр гаргах, хямралын дараагаар үйл ажиллагаагаа амжилттай жигдрүүлэх, сэргээх нь мөн чухал тул стратеги төлөвлөгөөний төслөө эдгээр үе шатыг хамруулан боловсруулж байна.

Мөн ББСБ, ХЗХ–дын активыг ангилах, зарцуулах, хяналт тавих журамд өөрчлөлт оруулсан. Ингэснээр иргэд, аж ахуй нэгжүүдийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах, тэдгээрийн зээлийн чанар муудан, зээлийн муу түүх үүсэхээс сэргийлэх боломжтой болсон. Зээлийн гэрээ нь үйлчлүүлэгч, санхүүгийн байгууллага хооронд хийгддэг учраас төрийн байгууллагын зүгээс уг харилцаанд шууд оролцох, нөлөө үзүүлэх боломж байдаггүй. Гэхдээ хөл хорионы улмаас иргэд, аж ахуй нэгжүүдийн хувьд зээлийн дарамт ихээр үүсэж байгаа учраас ББСБ–ын салбарын төлөөллүүдтэй тогтмол уулзан, уриалга, чиглэлийг хүргүүлсэн. Зах зээлийн оролцогч байгууллагууд маань ч мөн бидний гаргасан уриалгыг дэмжин хямралын эсрэг чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаад талархах нь зүйтэй. Тухайлбал ББСБ–ын салбарын хувьд салбартаа томоохонд тооцогддог нийт 34 байгууллага зээлийн хүү, шимтгэлээ бууруулах, зээлийн хугацаагаа сунгах зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээний бодлогодоо өөрчлөлт оруулж буйгаа

мэдэгдсэн. Эдгээр байгууллагуудын хувьд салбарын нийт зээлдэгчдийн 70 гаруй хувийг бүрдүүлдэг томоохон байгууллагууд юм. Энэ салбарт одоогийн байдлаар нийт 43.0 мянган зээлдэгч гэрээндээ өөрчлөлт оруулах хүсэлт гарган зээлийн гэрээгээ шинэчлээд байна.

Дан ганц ББСБ-ын салбар ч гэлтгүй даатгалын салбарт мөн онцгой нөхцөл байдалд ажиллаж буй албан хаагчдаа үнэ төлбөргүй хамруулах КОВИД-19 даатгалын бүтээгдэхүүн гарч, хөрөнгийн зах зээл, хадгаламж зээлийн хоршоодын оролцогчид маань үйл ажиллагаагаа цахимжуулан, шимтгэл, хураамжийн төлбөртөө уян хатан хандаж байгаад талархаж буйгаа дахин илэрхийлье.

Цар тахлын улмаас олон төрлийн эрсдэл, тодорхой бус байдал үүсэж байгаа хэдий ч аливаа өөрчлөлт, хувьсалд эерэг, давуу тал гэж байдаг. Таны хувьд цар тахалтай холбоотойгоор эерэг өөрчлөлт, ямар боломжууд гарч ирнэ гэж хүлээж байна вэ?

Мэдээж бүхий л зүйлсэд сайн муу 2 тал байдаг гэж бид ярьдаг. Халдварт өвчин тархан, дэлхийн эдийн засаг удааширч буй хэдий ч эргээд зах зээл, эдийн засаг хэвийн горимд шилжин, амьдрал үргэлжлэх тул бид энэ үйл явдлаас ч мөн сайн тал, боломжийг олж харах нь зүйтэй болов уу.

Санхүүгийн зах зээлийн хувьд ч мөн хэд хэдэн боломжууд үүсэж байна гэж харж байна. Нэгдүгээрт, халдварт өвчний тархалтын улмаас бид бэлэн мөнгөнөөс татгалзаж эхэлсэн. Техник, технологийн хөгжлийн хамгийн их дэвшил, хүртээмжийг авчирж буй салбаруудын нэг нь яах аргагүй санхүүгийн салбар юм. Хэрэглэгч,

үйлчлүүлэгчид бэлэн мөнгөнөөс татгалзан санхүүгийн харилцаандаа технологийг ашиглаж хэвших нь цаашдын зах зээлийн хөгжилд томоохон хувь нэмэртэй. Мөн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнээс гадна цаашид эрэлт нь улам нэмэгдэх нэг санхүүгийн үйлчилгээний төрөл нь даатгал юм. Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь биднийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, учрах эрсдэлээс үүдэх алдагдлыг хамгийн бага байлгах, цаашлаад санхүүгийн зах зээлд санхүүжилтийн томоохон эх үүсвэрийг нийлүүлдэг чухал салбар. Тэгэхээр иргэд, олон нийт даатгалын зах зээл, бүтээгдэхүүн, үйлчилгээний ач холбогдлыг илүү таньж эхэлж байгаа нь энэ салбарын хувьд томоохон боломж юм.

Мөн миний ажигласнаар цар тахал нь биднийг санхүүгийн хувьд илүү сахилга баттай, дархлаатай байх ёстойг сануулсан том сургамж болж байна. Бид хувь хүн, өрх гэр, бизнес, бүр улсынхаа хэмжээнд тодорхой хэмжээний эрсдэлийг тодорхой хугацаанд даагаад гарах чадамжтай байх шаардлагатай юм. Тийм учраас санхүүгийн сахилга баттай байх, хадгаламжтай, даатгалтай байх мөн хөрөнгөө төрөлжүүлэх, хөрвөх чадвартай байх зэрэг нэлээн чухал санхүүгийн хичээлүүдийг энэ үйл явдал бидэнд заагаад өгчих шиг боллоо.

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд мөн адил үйл ажиллагаагаа цахимжуулах, тусгай зөвшөөрөл, бүртгэлийн харилцааг цахимаар түргэн шуурхай шийдвэрлэх, зах зээлд оролцогч байгууллагууд, хувьцаат компаниуд, хадгаламж, зээлийн хоршоод маань хувьцаа эзэмшигчид, бүх гишүүдийн

хурлаа цахимаар явуулах зэрэг үйл ажиллагаагаа хөнгөвчлөх олон алхмуудыг амжилттай хэрэгжүүлж байгаа нь цаашдын бидний үйл ажиллагаанд ч мөн дэвшил болохоор байна.

Үнэ цэнэтэй мэдээлэл өгсөн танд баярлалаа. Таны зүгээс уншигчдадаа хандаж ямар зөвлөгөө өгөх вэ гэсэн асуултаар энэ удаагийн ярилцлагаа өндөрлөө.

Эдийн засаг, зах зээл өөрөө хүний үйл хөдлөл, шийдвэр гаргалтад суурилан ажилладаг гэдгийг дахин дурдахыг хүсэж байна. Корона вирусын тархалт, хорио цээрийн улмаас үүсээд буй эдийн засгийн уналт, тодорхой бус байдалд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь нийлүүлэлтийн тасалдал, хэрэглээ буюу эрэлтийн шок, эдгээрээс улбаатай эрдэс бүтээгдэхүүн, санхүүгийн зах зээлийн огцом савлагаа зэрэг хэдий ч иргэд, олон нийт үйлчлүүлэгчдийн үйл хөдлөл, зан төлөв, эдийн засаг зах зээлд итгэл өөрөө хамгийн гол хүчин зүйл нь байдаг. Тийм учраас иргэд, олон нийт маань үнэн зөв мэдээлэл авах, аливаа мэдээлэлд улсууртай хандах, мэргэжлийн байгууллагуудаас хүргүүлж буй зөвлөгөө, чиглэлийг сайтар мөрдөх, санхүүгийн мэдлэгээ нэмэгдүүлж, сахилга батаа сайжруулан ухаалаг шийдвэр гаргах нь хамгийн чухал юм.

Мэдээж эдийн засаг, санхүүгийн зах зээлээ буцаан сэргээхэд та бидний эрүүл мэнд, бүтээмж хамгийн чухал тул өөрсдийн эрүүл мэнд, дархлаагаа дэмжин аливаа эрсдэлээс өөрсдийгөө болон бусдыгаа хамгаалан, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, хамтдаа тэмцэх ёстой шүү гэдгийг сануулан уриалья.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

Даатгалын харилцааны эрх зүйн зохицуулалтын нэг хэлбэр нь даатгалын гэрээ юм. Даатгалын тухай хуульд зааснаар Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Иргэний хуулиар зохицуулна. Даатгалын тодорхой хэлбэрүүд нь даатгагч, даатгуулагч нарын хооронд байгуулсан даатгалын гэрээний үндсэн дээр хийгддэг. Монгол улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.1-д “Даатгалын гэрээгээр даатгагч нь даатгалын тохиолдол

бий болоход даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэж тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүргийг тус тус хүлээнэ. Өөрөөр хэлбэл даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид даатгалын нөхөн төлбөр төлөх үүрэгтэй байх, нөгөө талаас даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүрэг бүхий иргэний эрх зүйн хэлцлийг даатгалын гэрээ гэнэ.

Дээрх нөхцөлөөс үзэхэд Даатгалын гэрээ нь дараах үндсэн шинжтэй байна. Үүнд:

1. Даатгалын гэрээ зөвхөн хоёр талын гэрээ байна.

Даатгагч даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөр төлөх үүрэгтэй, даатгуулагчаас даатгалын хураамж төлөхийг шаардах эрхтэй байна. Даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүрэгтэй, даатгалын тохиолдол бий болоход учирсан хохирол буюу даатгалын нөхөн төлбөр төлөхийг шаардах эрхтэй байна.

2. Төлбөрийн шинжээрээ даатгалын гэрээ нь хариу төлбөртэй гэрээ байна.

Даатгалын гэрээний төлбөр нь даатгалын хураамж байна. Даатгалын хураамж гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг хэлнэ.

3. Даатгалын гэрээ нь биелэгдэх шинжээрээ урьдчилан тохиролцсон хэлцэл байна

Гэрээний талууд гэрээндээ болзол заагаад, уг нөхцөл байдал бий болсон тохиолдолд эрх үүрэг үүсдэг учраас урьдчилан тохиролцсон хэлцэл болдог. Өөрөөр хэлбэл даатгалын гэрээ байгуулснаар хэлцэл хүчин төгөлдөр болно. Даатгалын гэрээнд заасан даатгалын тохиолдол бий болсоноор даатгагч талд даатгалын нөхөн төлбөр олгох үүрэг, даатгуулагч талд даатгалын нөхөн төлбөр авах эрх үүснэ.

Даатгуулагч даатгалын гэрээг байгуулахдаа даатгагчтай шууд эсхүл даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчаар дамжуулан даатгалын гэрээ байгуулж болно.

Даатгуулагч даатгагчтай даатгалын гэрээ байгуулахдаа дараах зүйлсийг анхаарвал зохимжтой. Үүнд:

- Даатгалын гэрээ байгуулах даатгагч буюу даатгалын компани нь Даатгалын тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан эсэх;
- Даатгалын компаниас санал болгож байгаа даатгуулах гэж буй даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн нь Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн эсэх;
- Даатгалын гэрээнд даатгалын зүйл, даатгалын эрсдэлийн төрөл гэх мэт дээр дурдагдсан зүйлсийг тусгасан эсэх;
- Даатгалын нөхөн төлбөрийн хасалтыг судлах гэх мэт.

Даатгалын гэрээний нөхцөл

Монгол Улсын Иргэний хуулиар даатгалын гэрээний нөхцөл шаардлагыг тавьсан байдаг. Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.3–т “Даатгалын гэрээг бичгээр хийх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна. Даатгагч нь даатгалын гэрээ байгуулсныг гэрчилж даатгалын баталгаа олгоно. Даатгагч нь гарын үсэг зурсан даатгалын баталгааг даатгуулагчид гардуулах үүрэгтэй. Даатгалын баталгааг тодорхой этгээдэд нэр заасан буюу мэдүүлгийн баталгааны хэлбэрээр олгосон бол даатгал нь анхны даатгуулагчид тавих бүх шаардлагыг баталгаа эзэмшигчид гаргах болно. Харин Даатгалын баталгаа эзэмшигч нь даатгалтай холбогдсон эрхээ шилжүүлж байгаагаар даатгагчид мэдэгдсэн бөгөөд эрх шилжүүлэгч шаардлагаа нэн даруй гаргасан бол энэ журам хамаарахгүй.

Даатгалын гэрээнд дараах нөхцөлийг тусгадаг. Үүнд:

1. Даатгалын зүйл
2. Даатгалын эрсдэлийн төрөл
3. Даатгалын үнэлгээний хэмжээ
4. Даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл
5. Даатгалын хураамж, түүний төлөх хугацаа.
6. Даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага
7. Гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.

Даатгалын гэрээний хугацаа

Даатгалын гэрээний гол нөхцөлийн нэг нь даатгалын хугацаа юм. Даатгалын хугацаа нь даатгалын хэлбэр, зүйл, даатгалын ашиг

сонирхлоос хамааран харилцан адилгүйгээр тодорхойлогдоно. Даатгалын гэрээний хугацааг гэрээний талууд буюу даатгагч, даатгуулагч нар харилцан тохиролцон тогтооно.

Даатгалын хураамж

Даатгалын хураамжийг тогтоохдоо даатгалын үнэлгээг харгалзан тогтоодог. Даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1–т заасны дагуу албан журмын даатгалын хураамжийн хэмжээг Монгол улсын хуулиар тогтооно. Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тогтоох аргачлалын дагуу даатгагч тогтооно.

Мөн Иргэний хуулийн 437 дугаар зүйлийн 437.1 дэх хэсэгт заасны дагуу Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй бол даатгагч хураамж төлөх 15 хоногийн нэмэлт хугацаа тогтоож болох бөгөөд энэ хугацааг дахин хэтрүүлбэл үүсэх үр дагаврыг даатгагч бичгээр мэдэгдэнэ. Даатгуулагч нь даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй.

Даатгалын тохиолдол бий болохоос өмнө даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзсан бол даатгагч эрсдэлийг өөртөө хүлээж байсан хугацаанд тохирох даатгалын хураамж болон гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээнийхээ хөлсийг даатгуулагчаас шаардах эрхтэй байна. Мөн даатгагчийн төлбөрийн чадвар үлэмж доройтох, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахааргүй нөхцөл бий болсон бол даатгуулагч даатгалын хураамж төлөхөөс татгалзах эрхтэй.

Даатгалын гэрээг цуцлах, түүнд өөрчлөлт оруулах

Монгол Улсын Иргэний хуулийн 434–р зүйлийн 434.2–т зааснаар Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

1. Хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон
2. Даатгагч даатгуулагчийн аль нэг дампуурсан, татан буугдсан
3. Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон
4. Даатгуулсан эд хөрөнгийг шүүхийн шийдвэрээр хураасан
5. Талууд тохиролцож гэрээг цуцалсан
6. Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн

Даатгалын гэрээний хугацаанаас хамааран гэрээг цуцлах нөхцөлийг Иргэний хуульд мөн тусгасан байна. Энэ нь даатгалын гэрээг 5 жилээс илүү хугацаагаар байгуулсан бол нэг тал нь гэрээг цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 3 сарын дараа цуцалж болно. Даатгалын гэрээг нэг жилээс дээшгүй хугацаагаар сунгах нөхцөлтэйгөөр байгуулсан тохиолдолд талууд гэрээний хугацааг дуугүй хүлээн зөвшөөрөх замаар сунгах, даатгалын гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахгүй байх тохиролцоо хүчин төгөлдөр бус байна. Даатгагч даатгалын хураамжийг нэмэгдүүлсэн тохиолдолд даатгуулагч нь 1 сарын дотор гэрээг цуцалж болохоор байна.

ФИНТЕК БА РЕГТЕК

ФИНТЕКИЙН САЛБАР ДАХЬ ОНЦЛОХ МЭДЭЭЛЛҮҮД

The Global Fintech Index 2020

Дэлхийн 65 орны 230 гаруй хотыг хамарсан “The Global Fintech Index 2020” тайланг финтекийн салбарын судалгааны байгууллага болох Findexable –аас 2019 оны 12 дугаар сард гаргасан байна. Энэ индекс нь дэлхийн улс орнуудыг финтекийн үйл ажиллагаагаар нь

эрэмбэлж, бүс нутгуудийн финтекийн хөгжил ямар түвшинд явж байгааг харьцуулж харуулсан анхны индекс юм.

Тус индексийг гаргаж буй зорилго нь финтек төвүүд (hubs), шинэ санаанууд, трендүүдийг тодорхойлж, түүнийгээ бодит цаг хугацаанд харьцуулах боломжийг олон нийтэд олгож, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээг түгээж, хөгжүүлэх юм.

Хүснэгт 1. Улс орнуудын финтек индекс, эзлэсэн байр (Топ 10)

Байр	Өөрчлөлт	Улс	Оноо	Төрөлжсөн салбар	Финтек төв болсон хотууд (Топ 100-д багтсан)	Финтекийн салбарын тэргүүлэгчид
1	▶ 0	АНУ	31.789	Төлбөр тооцоо B2B финтек Цахим аюулгүй байдал	22	Stripe (\$22.5 bn) Coinbase (\$8 bn) Robinhood (\$5.6 bn)
2	▶ 0	Англи	23.262	Шинэ төрлийн банк Хувийн санхүү Зээл Блокчэйн	3	TransferWise (\$3.5 bn) Greensill (\$3.5 bn) BGL Group (\$3 bn)
3	▲ +18	Сингапур	19.176	Хөрөнгө удирдлага Дижитал банк ЖДҮ	1	TenX (\$159.1 m) Quoine (\$123 m) KyberNetwork (\$105 m)
4	▲ +14	Литва	17.343	Төлбөр тооцоо Зээл Шинэ төрлийн банк	1	Stockinvest us Coingate NEO Finance
5	▲ +3	Швейцар	16.018	Криптовалют Блокчэйн Хөрөнгө удирдлага Хамтын санхүүжилт	4	Avaloq Group Ethereum Numbrsa
6	▶ 0	Нидерланд	14.464	Төлбөр тооцоо Зээл Хөрөнгө оруулалт	2	Adyen, Ohpen, BUX
7	▶ 0	Швед	14.272	Төлбөр тооцоо ЖДҮ Шинэ төрлийн банк	1	Klarna, iZettle, Anyfin
8	▼ -3	Австрали	13.555	Төлбөр тооцоо Хувийн санхүү Зээл	2	Judo Capital, Airwallelex, MoneyMe
9	▼ -6	Канад	13.322	Криптовалют Блокчэйн Зээл Даатгал	5	Carta, Borrowell, Wave
10	▲ +3	Эстони	13.303	Төлбөр тооцоо Хувийн санхүү Зээл	1	Fortumo, Veriff

Эх сурвалж: The Global Fintech Index 2020, Findexable

Тус тайланг www.findexable.com
вэбсайтаас татаж авах боломжтой юм.



ФИНТЕК БА КОРОНАВИРУС КОВИД-19

Финтекийн компаниуд коронавирусын халдвартай холбоотой харилцан адилгүй хариу үйлдэл үзүүлээд байна.

КОВИД-19 нь финтек аппликэйшний ашиглалтыг мэдэгдэхүйц өсгөлөө (Forbes)


Дэлхийн олон улс орнууд хөл хорио тогтоосноор хүмүүст гэрээсээ гаралгүйгээр санхүүгийн болоод бусад үйлчилгээг авах шаардлага тулгараад байгаа билээ. Үүний нэг жишээ нь томоохон санхүүгийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын нэг болох deVere group компанийн гар утасны аппликэйшний хэрэглээ 72 хувиар өссөн байна. Өөр нэгэн жишээ нь Нэгдсэн вант улсад байршилтай Glint гэх алт арилжааны аппликэйшнийг гаргасан стартап компани алтны ханшны хэлбэлзэлтэй холбоотойгоор сарын хугацаанд алт худалдан авагчдын тоо 718 хувийн өсөлттэй байсныг мэдээлжээ. Мөн Филиппин улсын онлайн банкны үйлчилгээ үзүүлэгч RCBC банканд шинээр бүртгүүлсэн иргэдийн тоо сүүлийн сард 2 дахин өссөн зэргээр финтек аппликэйшнүүдийн ашиглалт өндөр байгаа олон жишээ гарсаар байна.

Гэсэн хэдий ч энэ нь КОВИД-19 бүх финтек компанид “сайнаар” нөлөөлж байна гэсэн үг биш юм.

2020 оны эхний улирлын байдлаар стартап компаниудад чиглэсэн хөрөнгө оруулалт бууралттай байна (CB insights)

Машин сургалт, их өгөгдөл зэрэг технологийн дэвшлүүдийг ашигладаг санхүүгийн зөвлөгөө, судалгааны байгууллага болох CB insights нь стартап компаниудын хөрөнгө оруулалтад КОВИД-19 хэрхэн нөлөөлж байгааг судалгаагаар харуулсан байна. Стартап компаниудын томоохон хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, эрсдэлийн, тэтгэврийн, хамтын сангууд, хөрөнгө оруулалтын банкууд зэрэг байгууллагуудын стартап компаниудад чиглэсэн хөрөнгө оруулалт 2020 оны 1 дүгээр улиралд буурсан дүнтэй гарсан байна.

Зураг 1. Нийт стартап компаниуд дахь хөрөнгө оруулалт



Эх сурвалж: CB Insights

Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх улирлаас 30 хувиар, хөрөнгө оруулалтын тоо 25 хувиар унасан үзүүлэлттэй байна.

Харин тус үзүүлэлтүүд АНУ-ын хувьд дараах байдалтай гарсан байна.

Зураг 2. АНУ-ын стартап компаниуд дахь хөрөнгө оруулалт



Эх сурвалж: CB Insights

Хэдийгээр 2020 оны 1 дүгээр улиралд АНУ дахь стартап компаниудын хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн байгаа ч энэхүү хөрөнгө оруулалт нь цөөн тооны томоохон хөрөнгө орууллагууд юм. Олон хөрөнгө оруулагчид эрсдэлээс зайлсхийн стартап зэрэг эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтыг хийхээс татгалзсан байна. Үүний нэг жишээ нь АНУ-ын томоохон эрсдэлийн сан болох Lone Pine Capital нь өмнөх улирлуудад TransferWise, Away, Snap, Uber зэрэг стартапуудад хөрөнгө оруулалтыг хийж байсан бол 2020 оны 1 дүгээр улиралд ямар ч стартап хөрөнгө оруулалтыг хийгээгүй байна.

КОВИД-19-ын халдварын Ази дахь стартап компаниуд дахь нөлөөлөл хүчтэй байна. Дараах зурагт хөрөнгө оруулалтын үзүүлэлтийг харууллаа.

Зураг 3. Азийн стартап компаниуд дахь хөрөнгө оруулалт



Эх сурвалж: CB Insights

Ази дахь стартап компаниудын хувьд хөрөнгө оруулалт сайтай байсан 2019 оны 4 дүгээр улирлыг бодоход энэ улирал хөрөнгө оруулалтын тооны хувьд 39 хувиар, хэмжээний хувьд 50 хувиар унасан үзүүлэлттэй байна.

2020 оны 2 дугаар улиралд энэхүү уналт үргэлжлэх эсэх нь КОВИД-19-ийн халдвараас нэлээдгүй хамааралтай болоод байна.

Засгийн газрууд стартап компаниудад туслах зорилгоор сан байгуулж байна (CB insights)

Шинэ коронавирусын халдвартай холбоотойгоор стартап компаниудад олгох зээл, санхүүжилт буурснаар олон стартап компаниуд санхүүгийн томоохон бэрхшээлтэй нүүр тулаад байна. Энэхүү асуудлаар улс орнууд ар араасаа бодлогын түвшинд зохицуулалтыг хийсээр байна. Хамгийн сүүлийн байдлаар буюу 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн мэдээллээр Нэгдсэн вант улсын Засгийн газраас стартап компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 1.25 тэрбум фунт стерлингийн Ирээдүйн санг байгуулсан байна. Үүний өмнөхөн Франц 4 тэрбум еврогийн, Герман 2 тэрбум еврогийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлэхээ зарласан байна.

Ирээдүйн сангийн 500 сая фунт стерлингийг өндөр өсөлттэй стартап компаниудад зээл хэлбэрээр олгох ба тус стартап компаниуд тус сангаас энэ оны 5 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд тус бүр 125.0 мянгаас 5.0 сая хүртэлх фунт стерлингийн зээлийн хүсэлт гаргах боломжтой. Зээлийн нэг шалгуур нь компани сүүлийн 5 жилийн хугацаанд дор хаяж 250.0 мянган фунт стерлингийн хөрөнгө оруулалтыг татсан байх ёстой. Харин үлдсэн 750 сая фунт стерлингийг жижиг болон дунд хэмжээний судалгаа, хөгжүүлэлтийн стартап компаниудад зээл, тусламжийн хэлбэрээр олгохоор тогтжээ.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ИТГЭЛЦҮҮР ГУРВЫГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ

ЧУЛУУНБААТАР АНХБАЯР, МУИС, БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ, ДОКТОР
ТОГТОХДОРЖ ШИЙРЭВ, “МИГ ДААТГАЛ” ХХК

Энэхүү бүтээл нь СЗХ-ноос 2019 оны 11 дүгээр сард зохиогдсон “Эрдэм шинжилгээний хурал”-ын судлаачийн ангилалд дэд байр эзэлсэн бүтээл бөгөөд СЗХ-ны байр суурийг илэрхийлээгүй болно.

ХУРААНГУЙ

Вейбулл хэлбэрийн тархалтыг ашиглан жолоочийн даатгалын нөхөн төлбөр гарах магадлалыг регрессийн тэгшитгэлээр тооцоолсон. Энэхүү магадлал нь насны онцлогоос хамааран тодорхойлогдоно. Судалгаанд 2016–2018 оны жолоочийн даатгалд давхардсан тоогоор хамрагдсан 805,844 даатгуулагч, нөхөн төлбөр авсан 45,063 даатгуулагчийн тоог хамруулсан. Судалгааны үр дүнд жолоочийн даатгалын итгэлцүүр гурвыг сайжруулах боломжтой гэж дүгнэсэн.

Түлхүүр үгс: Вейбулл тархалт, регрессийн тэгшитгэл, нөхөн төлбөр гарах магадлал

I. УДИРТГАЛ

Амьдралын даатгалын нас барах магадлалын тооцоонд өргөн хэрэглэгддэг тархалтуудын нэг нь Вейбулл тархалт юм. Тус тархалтыг анх Фрешет (Frechet, 1928) санал болгосноор экстремум хэлбэрийн тархалт хөгжих суурь тавигдсан. Фрешетийн тархалт нь Вейбулл хэлбэрийн тархалтын урвуу болохыг Валодди Вейбулл (Weibull, 1951) өөрөө тогтоож нарийвчлан судалсан. Вейбулл тархалт нь амьдралын даатгал, ердийн даатгал, давхар даатгалын нөхөн төлбөрийг загварчлах, инженерчлэлийн найдвартай байдал, цахилгааны инженерчлэл, үйлдвэрлэлийн дамжлагын явцад бүтээгдэхүүн задрах, үрэгдэх, бутрах үеийн гологдлыг тогтоох, цаг агаарын таамаглал, салхины хурдыг тогтоох, харилцаа холбооны интернет сүлжээний тасралтыг загварчлах, цахим хуудас дээрх мэдээллийн хандалт, экстремум утгын онол зэрэгт өргөн хэрэглэгдэх болсон

Энэхүү судалгааны ажлын зорилго бол зөвхөн хоёр параметрт Вейбулл тархалтыг үнэлэх явдал юм. Вейбулл тархалтын параметрийн үнэлгээг анх Хартер ба Мур (Harter and Moore, 1956) нар хамгийн их үнэний хувь бүхий аргаар үнэлсэн. Тус тархалтын нягтын функцийг Муд (Mood, 1974) Newton-Raphson-ны аргаар тооцоолсон. Харин Мартез ба Уоллер (Martez ба Waller 1982) нар Байесын аргыг ашигласан бол Суэйн (Swain, 1988) хамгийн бага квадратын аргыг хэрэглэсэн. Вейбулл тархалтын параметрийг үнэлэхдээ цаашид бид хамгийн бага квадратын аргыг ашиглана.

II. ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Нөхөн төлбөр гарах магадлалыг X гэе. Нөхөн төлбөр нь нас бүрийн онцлогоос шалтгаалан боломжит үр дүнгүүд нь ялгаатай, ижил нөхцөлд дахин давтагдах шинж чанартай тул санамсаргүй хэмжигдэхүүн байна. Иймд тархалтын функцийг насны онцлогоос хамааруулан

$$F(x) = P(X \leq x), \quad x \geq 0 \quad (1)$$

гэж тодорхойлно. Тэгшитгэл (1) нь нөхөн төлбөр гарах тархалтыг цаашид илэрхийлнэ. Энэхүү тархалтыг Огунтундре (Oguntundre, 2015) тодорхойлсноор дараах экспоненциалаас үүссэн Weibull тархалтаар бичиж болно.

$$F(x; a, b, \alpha, \beta) = \left[1 - \left\{ e^{-\left(\frac{x}{\beta}\right)^\alpha} \right\}^a \right]^b \quad (2)$$

Энд $x > 0, a > 0, b > 0, \alpha > 0, \beta > 0$ байна. Энэхүү тархалтаас дараах тархалтууд үүснэ.

- $a=1$ үед үүссэн вейбулл тархалт
 - $b=1$ үед экспоненциал вейбулл тархалт
 - $a=b=1$ үед вейбулл тархалт
 - $a = b = \alpha = \beta = 1$ үед экспоненциал тархалт
- Энэхүү судалгаанд $a=b=1$ гэж үзэх тул тархалтын функц (2) дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

$$F(x; \alpha, \beta) = 1 - e^{-\left(\frac{x}{\beta}\right)^\alpha} \quad (3)$$

Тархалтын функц (3)-н хоёр талаас хувиргалт хийн давхар логарифм авснаар

$$\ln(x) = \ln(\beta) + \frac{1}{\alpha} \ln \left[\ln \left(\frac{1}{1 - F(x)} \right) \right] \quad (4)$$

гэж олдоно. Энэхүү тэгшитгэлийн наснаас хамаарах магадлалыг Мартез ба Уоллер (Martez and Waller, 1982) нар

$$F(x_i) = \frac{A_i - 0.5}{A_{max} + 0.25} \quad (5)$$

Монтанари ба Каччиари (Montanari and Cacciari, 1988) нар

$$F(x_i) = 1 - \frac{A_{max} - A_i + 0.625}{A_{max} + 0.25} \quad (6)$$

гэж тус тус тогтоосон. Энд A_i нь i -р ангиллын насыг, A_{max} нь хамгийн өндөр насыг илэрхийлнэ. Тухайлбал i -р насны ангилал 18, хамгийн өндөр нас нь 86 бол томьёолол (5)-с 0.2029, томьёолол (6)-с 0.2043 гэсэн магадлалууд олдоно.

Томьёолол (5) ба (6) дээр суурилан тэгшитгэл (4)-г i -р индексээр илэрхийлэн дараах байдлаар бичиж болно.

$$Y_i = b_0 + b_1 P_i \quad (7)$$

Энд:

$$Y_i = \ln(x_i) \quad b_0 = \ln(\beta) \quad b_1 = \frac{1}{\alpha}$$

$$P_i = \ln \left[\ln \left(\frac{1}{1 - F(x_i)} \right) \right]$$

байна. Тэгшитгэл (7) нь насжилтын магадлалаас хамааран нөхөн төлбөр гарах магадлалыг илэрхийлнэ. Хэрэв үндсэн таамаглал $H_0: b_2 = 0$ биелэгдэж байх нөхцөлийг (7)-д оруулахад

$$Y_i = b_0 + b_1 P_i + b_2 P_i^2 \quad (8)$$

гэж илэрхийлж болно. Тус тэгшитгэлийн алдааны квадрат дундаж хамгийн бага байхаар (b_0, b_1, b_2) гэсэн параметруудийг тооцоолж болно. Иймд

$$MSE = E(Y - b_0 - b_1 P - b_2 P^2)^2 \quad (9)$$

байх ба энэхүү тэгшитгэлээс дараах шийдүүд олдоно.

$$\widehat{b}_0 = E(Y) - \widehat{b}_1 E(P) - \widehat{b}_2 E(P^2)$$

$$\widehat{b}_1 = \frac{Var(P^2) \cdot Cov(Y, P) - Cov(P, P^2) \cdot Cov(Y, P^2)}{Var(P) \cdot Var(P^2) - Cov(P, P^2) \cdot Cov(P, P^2)}$$

$$\widehat{b}_2 = \frac{Var(P) \cdot Cov(Y, P^2) - Cov(P, P^2) \cdot Cov(Y, P)}{Var(P) \cdot Var(P^2) - Cov(P, P^2) \cdot Cov(P, P^2)}$$

III. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ИТГЭЛЦҮҮР

Жолоочийн даатгалын тухай хууль нь 2011 оны 10 сарын 6-ны өдөр батлагдаж даатгалын салбарт 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар даатгалын хураамжийг тогтоохдоо томьёолол (10)-т тусгагдсан 9 итгэлцүүрийг авч үздэг.

$$P = P_0 \prod_{i=1}^9 I_i \quad (10)$$

Бидний судалгааны ажилд гол анхаарал татсан нь итгэлцүүр гурав буюу Даатгуулагчийн нас, авто тээврийн хэрэгсэл жолоодох туршлага юм. Тус итгэлцүүрийг насны хувьд 25 хүртэлх насны, 25 болон түүнээс дээш насных гэж зөвхөн хоёр хуваасан байдаг.

Даатгуулагчийн нас, авто тээврийн хэрэгсэл жолоодох туршлага	Итгэлцүүр	
25 хүртэлх насны	3 жил хүртэлх туршлагатай	1.20
	3 болон түүнээс дээш жилийн туршлагатай	1.15
25 болон түүнээс дээш насны	3 жил хүртэлх туршлагатай	1.10
	3 болон түүнээс дээш жилийн туршлагатай	1.00

Энэхүү хуваалт нь наснаас хамааран даатгалын тохиолдолд нь харилцан адилгүй байна гэсэн ердийн даатгалын итгэлцүүрийн онол, амьдралын даатгалын нас ахихын хирээр нас барах магадлал нэмэгдэнэ гэсэн онолуудаас үл хамаарч байна. Мөн нас болон жолоо барьсан туршлага хоёрын ойлголтын зөрүүг хооронд нь давхцуулснаар магадлалын онолоор аль нь алиныхаа шалтгаан болохыг тогтооход хүндрэл үүсгэж байна. Эдгээр онолын дутагдалтай талыг сайжруулах үүднээс итгэлцүүр гурвыг дараах байдлаар тодорхойлж болно.

$$I_3 = [1 + P(I_3^{(1)})] [1 + P(I_3^{(2)} | I_3^{(1)})] \quad (11)$$

Энд

$P(I_3^{(1)})$ —наснаас хамааран нөхөн төлбөр гарах магадлал

$P(I_3^{(2)} | I_3^{(1)})$ —тухайн насанд харгалзах жолоо барих туршлагаас хамааран нөхөн төлбөр гарах магадлал

Онолын хэсэгт дурдсанаар наснаас хамааран нөхөн төлбөр магадлал нь


$$P(I_3^{(1)}) = x_i \quad (12)$$

байна.

IV. ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Бид энэхүү судалгаанд давхардсан тоогоор жолоочийн даатгалд хамрагдсан 805844 даатгуулагч, нөхөн төлбөр авсан 45063 даатгуулагчийн тоон мэдээллийг ашиглав. Эдгээр тоон мэдээллийг зураг 4 ба 5-д харуулав.


Зураг 1. Нийт даатгуулагчийн тоо



Эх сурвалж: Албан журмын даатгагчдын холбоо (2016–2018 оны тоон үзүүлэлт)

Зураг 1-с харахад жолоочийн даатгалаар 25000-с дээш ангилалд 26–40 насныхан, 15000–25000 хүртэлх ангилалд 23–25, 41–48, 15000-с доош ангилалд 18–22, 49–86 насныхан хамаарагдаж байна.

Зураг 2. Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо



Эх сурвалж: Албан журмын даатгагчдын холбоо (2016–2018 оны тоон үзүүлэлт)

Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тооны хувьд 1500-с дээш ангилалд 23–35 насныхан, 500–1500 хүртэлх ангилалд 20–22, 36–52 насныхан, 500-с доош ангилалд 18–19, 53–86 насныхан хамаарч байна. Дээрх хоёр зураглалын давхцлаас харахад 26–35 насныхан хамгийн их даатгал хийлгэж, хамгийн их нөхөн төлбөрийг авчээ.

V. ЗАГВАРЫН ШИНЖИЛГЭЭ

Онолын хэсэгт дурдсан Мартез ба Уоллер, Монтанари ба Каччиари нарын арга зүйн дундаж утгаар наснаас хамаарах магадлалын утгыг тооцоолсон. Энэхүү утга нь дараах томъёогоор бодогдсон.

$$F(x_i) = -\left[\frac{A_i - 0.5}{A_{max} + 0.25} + 1 - \frac{A_{max} - A_i + 0.625}{A_{max} + 0.25}\right] = \frac{A_i - 0.4375}{A_{max} + 0.25} \quad (13)$$

Үүний дараа тэгшитгэл (7)-д харуулсан

$$P_i = \ln \left[\ln \left(\frac{1}{1 - F(x_i)} \right) \right]$$

тооцсон. Харин нөхөн төлбөр гарах магадлалыг нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоог нийт даатгуулагчийн тоонд харьцуулж тооцсон. Өөрөөр хэлбэл зураг 5-г зураг 4-т харьцуулсан болно. Гарсан утгаас логарифм авах замаар тэгшитгэл (7)-н

$Y_i = \ln(x_i)$ тооцогдсон.

Тооцоологдсон Y_i, P_i, P_i^2 н дундаж болон ковариацийн матрицыг доор харуулав.

$$\begin{pmatrix} E(Y) \\ E(P) \\ E(P^2) \end{pmatrix} = \begin{pmatrix} -3.127 \\ -0.092 \end{pmatrix}$$

$$\begin{pmatrix} Var(Y) & Cov(Y, P) & Cov(Y, P^2) \\ Cov(P, Y) & Var(P) & Cov(P, P^2) \\ Cov(P^2, Y) & Cov(P^2, P) & Var(P^2) \end{pmatrix} = \begin{pmatrix} 0.220 & -0.269 & 0.115 \\ -0.269 & 0.561 & -0.067 \\ 0.115 & -0.067 & 0.383 \end{pmatrix}$$

Эдгээр утгуудыг ашиглан параметруудийг тооцоолоход

$$\hat{b}_1 = \frac{(-0.269) - (-0.067)}{0.561 \cdot 0.383 - (-0.067) \cdot (-0.067)} = -0.4545$$

$$\hat{b}_2 = \frac{0.561 \cdot 0.115 - (-0.067) \cdot (-0.269)}{0.561 \cdot 0.383 - (-0.067) \cdot (-0.067)} = 0.2199$$

$$\hat{b}_0 = -3.127 - (-0.4545)(-0.092) - 0.2199 \cdot 0.569 = -3.2943$$

гэж олдоно. Үнэлгээний дэлгэрэнгүй үр дүнг хавсралтад харуулсан ба параметрууд болон загварын төлөөлөх чадвар t, F тестийн статистикийн хувьд бүрэн ач холбогдолтой байна. Эдгээр параметрийг ашиглан насжилтаас хамаарах нөхөн төлбөр гарах магадлалыг дараах функцээр тооцоолно.

$$x_i = \exp \left[-3.29 - 0.45 \cdot \ln \left(\frac{1}{1 - \frac{A_i - 0.4375}{A_{max} + 0.25}} \right) + 0.22 \ln \left(\ln \left(\frac{1}{1 - \frac{A_i - 0.4375}{A_{max} + 0.25}} \right) \right)^2 \right]$$

Энэхүү томъёогоор тооцоолсон үр дүнг доорх хүснэгтийн загварын тооцоолол гэсэн хэсэгт харуулав.

Нас	Нөхөн төлбөр гарах магадлал	Загварын тооцоолсон нөхөн төлбөр гарах магадлал x_i	Санал болгож буй итгэлцүүр $1 + x_i$	Нас	Нөхөн төлбөр гарах магадлал	Загварын тооцоолсон нөхөн төлбөр гарах магадлал x_i	Санал болгож буй итгэлцүүр $1 + x_i$
18	0.071	0.118	1.10	53	0.048	0.038	1.04
19	0.135	0.110	1.10	54	0.049	0.038	1.04
20	0.119	0.103	1.10	55	0.052	0.037	1.04
21	0.112	0.097	1.10	56	0.049	0.037	1.04
22	0.096	0.092	1.09	57	0.049	0.036	1.04
23	0.093	0.087	1.09	58	0.044	0.036	1.04
24	0.093	0.083	1.08	59	0.039	0.035	1.03
25	0.076	0.079	1.08	60	0.041	0.035	1.03
26	0.076	0.076	1.08	61	0.040	0.034	1.03
27	0.074	0.073	1.07	62	0.026	0.034	1.03
28	0.063	0.070	1.07	63	0.042	0.033	1.03
29	0.069	0.067	1.07	64	0.036	0.033	1.03
30	0.059	0.065	1.07	65	0.030	0.033	1.03
31	0.058	0.063	1.06	66	0.033	0.032	1.03
32	0.053	0.061	1.06	67	0.034	0.032	1.03
33	0.061	0.059	1.06	68	0.027	0.032	1.03
34	0.051	0.057	1.06	69	0.035	0.032	1.03
35	0.056	0.055	1.06	70	0.030	0.031	1.03
36	0.044	0.054	1.05	71	0.026	0.031	1.03
37	0.047	0.053	1.05	72	0.014	0.031	1.03
38	0.045	0.051	1.05	73	0.020	0.031	1.03
39	0.043	0.050	1.05	74	0.037	0.030	1.03
40	0.044	0.049	1.05	75	0.024	0.030	1.03
41	0.043	0.048	1.05	76	0.029	0.030	1.03
42	0.043	0.047	1.05	77	0.041	0.030	1.03
43	0.042	0.046	1.05	78	0.026	0.030	1.03
44	0.044	0.045	1.04	79	0.035	0.029	1.03
45	0.045	0.044	1.04	80	0.035	0.029	1.03
46	0.044	0.043	1.04	81	0.011	0.029	1.03
47	0.052	0.042	1.04	82	0.019	0.029	1.03
48	0.048	0.041	1.04	83	0.016	0.029	1.03
49	0.045	0.041	1.04	84	0.026	0.030	1.03
50	0.047	0.040	1.04	85	0.056	0.030	1.03
51	0.049	0.039	1.04	86	0.067	0.031	1.03
52	0.041	0.039	1.04				

VI. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын онолын хэсэгт дөрвөн параметртэй Огунтундре тодорхойлсон Вейбулл тархалтыг авч үзсэн ба хоёр параметртэй тохиолдолд үнэлгээ хийх регрессийн загварыг томъёолов. Насжилтыг магадлалаар илэрхийлэхдээ Мартез ба Уоллер, Монтанари ба Каччиари нарын арга зүй дээр суурилав.

Жолоочийн даатгалын итгэлцүүр гурвыг сайжруулах үндэслэлийг итгэлцүүрийн онол дээр тулгуурлав. Даатгалын салбарын статистикаас харахад жолоочийн даатгалаас олох даатгалын үр ашиг цаашид тогтвортой өсөхөөр байна.

Жолоочийн даатгалын хамралт 26–35 насныханд дийлэнх нь төвлөрчээ. Загварын параметрууд статистикийн хувьд ач холбогдолтой, загварын тайлбарлах чадвар боломжийн гарсан. Иймээс Вейбулл тархалтын өргөтгөсөн хувилбарыг насжилтаас хамаарах жолоочийн даатгалын нөхөн төлбөрт хэрэглэж, холбогдох итгэлцүүрт ашиглах боломжтой гэж дүгнэж байна.

Загварын тооцооллын үр дүнгээс 1.1 итгэлцүүрийг 18–21, 1.09 итгэлцүүрийг 22–23, 1.08 гэсэн итгэлцүүрийг 24–26, 1.07 гэсэн итгэлцүүрийг 27–30, 1.06 гэсэн итгэлцүүрийг 31–35, 1.05 гэсэн итгэлцүүрийг 36–43, 1.04 гэсэн итгэлцүүрийг 44–58, 1.03 гэсэн итгэлцүүрийг 59–с дээш насныханд хэрэглэхэд тохиромжтой гэсэн саналыг дэвшүүлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] Weibull, W.: A Statistical Distribution Function of Wide Applicability. *Journal of Applied Mechanics*, 18, 293–297 (1951).
- [2] Bebbington, M., Lai, C.D. and Zitikis, R.: A Flexible Weibull Extension. *Reliability Engineering & System Safety*, 92, 719–726 (2007).
- [3] Zhang, T. and Xie, M.: On the Upper Truncated Weibull Distribution and Its Reliability Implications. *Reliability Engineering and System Safety*, 96, 194–200 (2011).
- [4] Mudholkar, G.S. and Srivastava, D.K.: Exponentiated Weibull Family for Analysing Bathtub Failure-Rate Data. *IEEE Transaction on Reliability*, 42, 299–302 (1993).

[5] Marshall, A. W. and Olkin, I.: A New Method of Adding a Parameter to a Family of Distributions with Application to the Exponential and Weibull Families. *Biometrika*, 84, 641–652 (1997).

[6] Xie, M. and Lai, C.D.: Reliability Analysis Using an Additive Weibull Model with Bathub Shaped Failure Rate Function, *Reliability Engineering & System Safety*, 52, 87–93 (1996).

[7] Famoye, F., Lee, C. and Olumolade, O.: The Beta-Weibull Distribution. *Journal of Statistical Theory and Applications*, 4, 121–136 (2005).

[8] Phani, K.K.: A New Modified Weibull Distribution Function. *Communications of the American Ceramic Society*, 70, 182–184 (1987).

[9] Silva, G.O., Ortega, E.M, and Cordeiro, G.M.: The Beta Modified Weibull Distribution, *Lifetime Data Analysis*, 16, 409–430 (2010).

[10] Cordeiro, G. M., Ortega, E.M, and Da Chunha, D. C.: The Exponential Generalized Class of Distribution, *Journal of Data Science*, 11, 127 (2013).

[11] Oguntunde, P., Odetunmbi, O, and Adejumo, A.: On the Exponentiated Generalized Weibull Distribution: A Generalization of the Weibull Distribution, *Journal of Science and Technology*, 8, 1–7, (2015).

[12] Harter, H. L. and Moore, A. H.: Maximum Likelihood Estimation of the Parameters of Gamma and Weibull Population from Complete and Censored samples, *Technometrics*, 7 (4) (1956).

[13] Mood, A. M., Graybill, F. A. and Boes, C. D.: Introduction to the theory of Statistics. 3rd Edition, McGraw Hill, Kogkusha (1974).

[14] Martz, H. F. and Waller, R. A.: "Bayesian Reliability Analysis," John Wiley & Sons, New York, (1982).

[15] Swain, J., Venkatraman, S. and Wilson, J.: Least Squares Estimation of Distribution Functions in Jonhson's Translation System. *Journal of Statistical Computation and Simulation*, 29, 271–297 (1988).

[16] Montanari, G.C, and Cacciari, M.: Progressively Censored Aging Tests on XLPE-Insulated Cable Models, *IEEE Transactions on Electrical Insulation*, 23, 365–372 (1988).

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН



**ЗЭЭЛИЙН БАТЛАН
ДААЛТЫН САН**

дүгээр сарын 06-ны өдөр Сангийн дүрэм батлагдсанаар "Зээлийн Батлан Даалтын Сан" үүсгэн байгуулагдсан.

Сангийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо юм.

Зээлийн Батлан Даалтын Сан /ЗБДС/ нь банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм.

Монгол Улсын Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан. 2012 оны 11

Сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангаж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх зорилготой. Уг зорилгын хүрээнд байгуулагдсанаас хойш 2020 оны 1-р улирлын байдлаар нийт 788 жижиг дунд үйлдвэр эрхлэгчид 213.2 тэрбум төгрөгийн зээлд 103.2 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргасан байна.

Бүтэц зохион байгуулалтын хувьд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Гүйцэтгэх захирал, Зээлийн батлан даалтын хороо, Дэд захирал, газар нэгжүүд болон 21 аймаг дахь орон тооны бус төлөөлөгчид гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.



Батлан даалтын бүтээгдэхүүнүүд:

Зээлийн батлан даалтын сан хоёр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Сангийн өөрийн хөрөнгөөр баталгаа болгож гаргадаг ердийн батлан даалт буюу үндсэн батлан даалтын бүтээгдэхүүн. Тус бүтээгдэхүүний хүрээнд арилжааны 13 банктай хамтарч ажилладаг бөгөөд барьцаа хөрөнгийн дутагдалтай банк санхүүгийн байгууллагын эх үүсвэртэй зээл хүссэн ААН, байгууллагад зориулагдсан байдаг. Батлан даалтын нөхцөл нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн хүссэн зээлийн 60 хүртэл хувьд буюу батлан даалтын дээд хэмжээ нь 500 сая хүртэл төгрөг байна. Хоёрдугаарт, Зээлийн батлан даалтын сангаас Азийн хөгжлийн банкт хамтран хэрэгжүүлж буй эх үүсвэртэй батлан даалтын бүтээгдэхүүн юм.

Эх үүсвэртэй батлан даалт нь ердийн батлан даалтаас онцлогтой байдаг. Сан нь гаргасан батлан даалтын хэмжээгээр эх үүсвэрийг БСБ-тай хамтарсан хэлбэрээр бүрдүүлдэг учраас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хүү багатай, урт хугацаатай зээл авах боломжийг олгодог. 2021 он хүртэл нийт 60 сая ам.долларын санхүүжилтийг жилд 12 сая ам.доллараар татан авах ба төслийн хүрээнд нэг тэрбум хүртэлх төгрөгийн зээлд, нийт зээлийн дүнгийн 30–60 хувьд батлан даалт гаргах үйлчилгээ үзүүлдэг.

Батлан даалттай зээлийн хувьд жилийн 12–15 хувийн хүүтэй, 10 жил хүртэлх хугацаатай, хүү бага хугацаа урт учраас зээл авсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид санхүүгийн дарамт бага байдаг. Иймээс энэхүү төсөл нь импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэхэд үр өгөөжөө өгдөг юм. Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Хас банк, Капитрон банк гэсэн таван банкт хамтран ажиллаж байна.

Батлан даалт гаргуулах зээлдэгч ямар шаардлага хангасан байх вэ?

Жижиг дунд үйлдвэр эрхлэгчид маань зээл авахыг хүссэн боловч барьцаа хөрөнгө хүрэлцдэггүй байх, 1 жилийн турш үйл ажиллагаа явуулсан санхүүгийн орлоготой байх, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч /ЖДҮЭ/ аж ахуй нэгжээр бүртгүүлж, тодорхойлолт авсан байх, зээл авах хүсэлт гаргахаас өмнөх 6 сарын хугацаанд зээлдэгч, түүний холбогдох этгээд нь чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл, баталгаа, батлан даалт, түүнтэй адилтгах аккредитивын өргүй байх гэсэн үндсэн шаардлагуудыг хангасан бол батлан даалт гаргуулах боломжтой.

Батлан даалтад хэрхэн хамрагдах вэ?

Батлан даалт гаргуулах үйл явц үндсэн хоёр хэсэгтэй. Эхлээд батлан даалт гаргуулахыг хүссэн ААН, байгууллага сантай гэрээтэй арилжааны банканд зээл авах хүсэлтээ гаргана. Банк нь Зээлийн батлан даалтын санд хүсэлтийг уламжилна.

Банк тухайн зээлдэгчийн зээлийн судалгааг хийж холбогдох дүгнэлт шийдвэрээ ЗБДС-нд ирүүлдэг. Сангаас зээлдэгчийн үйл

ажиллагаанд батлан даалтын судалгаа хийж, ажлын 14 хоногийн хугацаанд батлан даалт гаргаж болох эсэх асуудлыг харгалзан үзэж шийдвэр гаргадаг.

Хамтын ажиллагаа

Зээлийн батлан даалтын сангийн хамтын ажиллагааны чиглэл нь БСБ-тай хамтын ажиллагааг өрнүүлж улмаар ЖДҮЭ-ийг дэмжин ажиллахад оршино. Зээлийн батлан даалтын сан нь Олон улсын Ази номхон далайн батлан даалтын сангуудын холбоо / ACSIC/-н отгон гишүүн байгууллага бөгөөд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, Монголын банкны холбоо зэрэг байгууллагуудтай дотоод болон гадаад хамтын ажиллагаа өрнүүлэн ажиллаж байна. Мөн Монголын хөрөнгийн биржийн хөрөнгийн зах зээл дээрх өрийн бичигт батлан даалтын үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн тогтолцоотой ба Санхүүгийн зохицуулах хорооны хяналтан дор үйл ажиллагаагаа явуулж байна. Дээрх бүх хамтран ажиллагч байгууллагуудтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан батлан даалтын шинэ бүтээгдэхүүн гаргах, нэвтрүүлэх, мэдээллээр хангах, мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллаж байна.

Бодлого

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар, Санхүүгийн зохицуулах хороо Сангийн өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэгтэй.

Тус хуулийн заалтад тусгагдсанаар Санхүүгийн зохицуулах хороо нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг өргөжүүлэх, сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмын хэрэгжилтийг хангах, банк бус санхүүгийн байгууллагын харилцагч жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд гаргах батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, өрийн дарамтыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Азийн хөгжлийн банкт хамтран хэрэгжүүлж буй төслийн хэрэгжилтийг сайжруулах замаар Сангийн санхүүгийн чадавх, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх тал дээр хяналт тавин ажиллаж байна.

Түүнчлэн сан нь Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан ЖДҮЭ-г дэмжих бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулан явуулдаг.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ


Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог сайжруулахад:

1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн гаргасан өрийн бичигт батлан даалт гаргах үйл ажиллагааг оновчтой тодорхойлон хэрэгжүүлэх зорилгоор Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулинд өөрчлөлт оруулах;
2. Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах;
3. Харилцагч байгууллагууд болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, БСБ-уудын хоорондын холбоог сайжруулах зорилгоор сангаас бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх сургалт зохион байгуулах;
4. ЖДҮЭ-д хүртээмжтэй шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд бий болгох, хүргэх;
5. ЗБДС нь санхүүгийн хувьд чадамжтай, олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулах, тогтолцооны хувьд шинэлэг, тогтвортой, нээлттэй ил тод зарчмыг баримтлах тал дээр анхааран ажиллаж байна.

БАТЛАН ДААЛТАД ХЭРХЭН ХАМРАГДАХ ВЭ?


Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч батлан даалт гаргуулах хүсэлт гаргах.




Банк судалгаа хийж, дүгнэлт, Зээлийн хорооны хурлын шийдвэр гаргах.



Батлан даалт гаргуулах зээлдэгчтэй батлан даалтын болон зээлийн гэрээ байгуулах.




Батлан даалтын судалгаа хийж, Зээлийн батлан даалтын хорооны шийдвэр гаргаж, банканд хүргүүлэх

ӨРГӨН ДУРАН

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ЦАХИМ УУЛЗАЛТ

“Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдөл” ажлын хэсгийн менежментийн цахим уулзалт:



Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /СХН/-ийн Хүртээмжийн тоон өгөгдөл /Financial Inclusion Data/ ажлын хэсгийн уулзалт цахим хэлбэрээр 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж

өнгөрлөө. Корона вирус цар тахлын улмаас дэлхий нийтээр хөл хорио тавигдсантай холбогдуулан энэ удаагийн ажлын хэсгийн уулзалтыг ийнхүү цахимаар зохион байгуулсан бөгөөд хуралдаанаар СХН-ийн менежмент, үйл ажиллагаа болон ажлын хэсгийн цаашдын зорилго, төлөвлөгөө, дэд ажлын хэсгүүдийн ажиллах зарчмыг хэлэлцсэн.

Хүртээмжийн тоон өгөгдөл ажлын хэсэг нь “Санхүүгийн хүртээмж дэх жендерийн асуудал”, “Хүртээмжтэй ногоон санхүүжилт”, “Хүртээмжийн стратегийн хяналт, үнэлгээ”, “Санхүүгийн зах зээлийн олон улсын стандарт”, “Технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалт” гэсэн 5 дэд ажлын хэсгээс бүрддэг. Ажлын хэсгийн уулзалтаар дэд ажлын хэсгүүд өөрсдийн чиг үүргийн хүрээнд боловсруулж буй бодлогын баримт бичиг, гарын авлага, судалгааны ажил, түүний явцыг танилцуулсан. Манай улсын хувьд өмнө нь санхүүгийн хүртээмжийг хэрэглэгчийн эрэлт талаас үнэлэх чиг үүрэг бүхий “Хүртээмжийг үнэлэх хэрэглэгчид төвлөрсөн аргачлал” сэдэвт дэд ажлын хэсэгт харьяалагддаг байсан бөгөөд ажлын хэсгийн зүгээс хүртээмжийн эрэлт талын судалгаа явуулахад шаардагдах аргачлалыг боловсруулан, амжилттай тайлагнаж, тус ажлын хэсэг хаагдан “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” дэд ажлын хэсэг байгуулагдсан. Одоогоор СЗХ уг шинээр байгуулагдсан дэд ажлын хэсэгт харьяалагдаж буй бөгөөд манай улсаас гадна Армен, Бангладеш, Сан Томе ба Принсип, Вануату, Фижи зэрэг улс орнууд гишүүнчлэгдэж байна. Дэд ажлын хэсэг одоогоор хөдөө аж

ахуйн даатгалын асуудлаар кэйс судлагдахуун, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний тоон өгөгдлийн талаарх түүвэр судалгааг гишүүн орнуудаас авахаар ажлаа төлөвлөөд байна.

“Хүртээмжтэй ногоон санхүү” ажлын хэсгийн цахим уулзалт:

“Хүртээмжтэй ногоон санхүү ажлын хэсэг (ХНСАХ) нь 2020 оны ажлын хэсгийн уулзалтуудаа цаг үеийн нөхцөл шаардлагаас үүдэн цахим хэлбэрээр 4 удаа зохион байгуулаад байна. Монгол Улсын хувьд тус ажлын хэсгийн “Ногоон санхүүгийн салбар дахь төв банкны үүрэг” дэд ажлын хэсэгт харьяалагдан ажиллаж байгаа бөгөөд зохион байгуулагдсан бүх уулзалт, семинаруудад идэвхтэй хамрагдаж байна. “Хүртээмжтэй ногоон санхүүгийн ажлын хэсэг”-ийн 1-р цахим уулзалтад 2020 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр ХНСАХ-ийн захирал, менежментийн албанаас ХНСАХ-ийн стратеги, Маяагын тунхаг, улс орнуудын хэрэгжилт, өгөгдлийн портал, хүйсийн хүртээмжтэй санхүү чиглэлээр танилцуулга хийсэн.

“Хүртээмжтэй ногоон санхүү ба тогтвортой хөгжлийн зорилтуудын танилцуулга” сэдэвт 2-р цахим уулзалтад 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн ХНСАХ-ийн захирал, менежментийн албанаас хүртээмжтэй ногоон санхүү ба тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар танилцуулга илтгэл тавьсан.

“Уур амьсгалын ба гамшигийн эрсдэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх нь” сэдэвт 3-р цахим уулзалт 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулагдаж уур амьсгалын эрсдэлийн даатгал, эрсдэлд тэсвэртэй байдлын зохицуулалт, тулгарч буй асуудлуудыг хэлэлцсэн.

“Ногоон санхүүгийн салбар дахь төв банкны үүрэг” дэд ажлын хэсгийн 1-р цахим уулзалт 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулагдаж ажлын хэсгийн ахлагч “Санхүүгийн хүртээмж, уур амьсгалын өөрчлөлт ба хүртээмжтэй ногоон санхүү” сэдвээр илтгэл тавьсан. Мөн энэ сэдвийн хүрээнд нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.



“Дижитал санхүүгийн үйлчилгээ” ажлын хэсгийн цахим уулзалт:

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн “Дижитал санхүүгийн үйлчилгээ” ажлын хэсгийн уулзалт 2020 оны 4 дүгээр сарын 02–ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдаж нийт 48 гишүүн орны 70 оролцогч оролцлоо. Цахим уулзалтаар ажлын хэсгээс боловсруулсан баримт бичгийн үйл явц, ахиц дэвшил, цаашид хийх шаардлагатай шинэчлэлүүдийн талаар ярилцсан. Одоогийн байдлаар уг ажлын хэсгээс нийт 5 бодлогын баримт бичиг, зөвлөмж болон тайлангуудыг эцэслэн гаргасан. Тэдгээр нь Санхүүгийн хүртээмж болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн гарын авлага, Финтекийн экосистемийг бий болгоход зохицуулагч байгууллагуудын үүрэг оролцооны талаарх тайлан, Эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын баримт, Хариуцлагатай дижитал зээл бодлогын баримт бичиг, Зохицуулалтын сэндрбок хөгжүүлэх зөвлөмж зэрэг юм. Харин дараах баримт бичгүүдийг ойрын хугацаанд эцэслэн боловсруулахаар төлөвлөж байна. Үүнд, Цахим санхүүгийн үйлчилгээг хүргэхэд

харилцагчдын эрх ашгийг хамгаалах тухай бодлогын баримт, Цахим санхүүгийн үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх тухай зөвлөмж, QR кодын стандартчлалын талаарх зөвлөмж, Дата мэдээллийн нууцлал, хамгааллын талаарх бодлогын зөвлөмж, Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд Регтекийг ашиглах нь тайлан зэрэг багтаж байна.



Цаашид шинэ коронавирусийн тархалттай холбоотойгоор уг ажлын хэсгийн дэд ажлын хэсгүүд тогтмол хугацаанд цахим уулзалт хийх, улс орнуудын зохицуулагч байгууллагын зүгээс өвчний үед санхүүгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаар туршлага солилцох тал дээр идэвхтэй анхаарч ажиллахаар төлөвлөөд байна.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

» Эхлэл 1–р нүүрт

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙ БОЛОВСРОЛД ЗОРИУЛЖ ТЕЛЕ ХИЧЭЭЛ ЯВУУЛЖ БАЙНА



Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо нь БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвтэй хамтран “Хувьцаа 1072”, “Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалал”, “Мөнгө угаахтай тэмцэх”, “Даатгал” сэдвээр теле хичээл бэлдэж Стар ТВ-ээр түгээж эхэлсэн бөгөөд www.frc.mn болон фэйсбүүк цахим хуудаснаас нөхөж үзэх боломжтой юм.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ






САНГИЙН ЯАМ



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Иргэдийн санхүүгий боловсролд зориулж богино хэмжээний видео шторк гаргалаа

Санхүүгийн зохицуулах хорооноос иргэдийн санхүүгийн боловсролд зориулж “Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох вэ?”, “Та даатгуулах хэрэгтэй юу?”, “Үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах тухай”, “Жолоочийн хариуцлагын даатгал”, “Мөнгө угаах гэж юу вэ?”, “Хувьцаа 1072” зэрэг сэдвээр богино хэмжээний анимейшн бэлтгэж олон нийтэд түгээлээ. Энэхүү мэдээллийг Хорооны цахим хуудас, твиттер, Монголбанк, Насан туршийн боловсролын үндэсний төв болон Хорооны 21 аймаг, 9 дүүргийн орон нутгийн төлөөлөгчөөр дамжуулан хүргэж байна.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН ОНЦЛОГ БА ЯЛГАА

Комплайнсын хяналтын чиг үүргүүдийг харахад санхүүгийн байгууллагуудын дотоод аудит болон дотоод хяналтын чиг үүрэгтэй ижил байдал ажиглагддаг бөгөөд “Базелийн хороо”-ноос комплайнсын хяналт болон дотоод аудит, дотоод хяналтын чиг үүргүүдийг тусгаарлах, комплайнсын хяналтын үйл ажиллагааг тодорхой цаг хугацааны үечилсэн байдлаар үнэлж байхыг зөвлөсөн.

Хараат бус бие даасан үнэлгээ хийх (дотоод аудит) болон комплайнсын эрсдэлийг тогтоох, удирдах аргачлалыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд чиг үүрэг зорилтуудын хувьд ч өөр өөр байдаг тул байгууллага дотоод аудит, дотоод хяналт болон комплайнсыг хэрэгжүүлэх мэргэжилтнүүдийн чиг үүргийг нарийн тодорхойлж өгөх нь зүйтэй байдаг.

Байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоонуудын чиг үүргийг тодорхойлбол:

Дотоод хяналт: Байгууллагын зорилтыг биелүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд тусгагдан, байгууллагын бүх ажилтнууд мөрдөн биелүүлэхэд хяналт тавина.

Комплайнсын хяналт: Бодлого, төлөвлөгөө, дагаж мөрдөх стандарт, аргачлал болон хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах тухайн байгууллагын хяналтын тогтолцоо юм.

Дотоод аудит: Дотоод аудитын зорилтууд нь комплайнсын хяналтын үйл ажиллагаанаас илүү өргөн утгыг хамрах ба байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагаа юм. /Энэ нь системтэй, оновчтой арга барилаар байгууллагын эрсдэлийн удирдлага, засаглал ба дотоод хяналтын үйл явцыг үнэлэх ба сайжруулахад тусалдаг./

Дээрх хяналтын аль нэгийг хэрэгжүүлэх тохиолдолд өөр өөр чиг үүргүүд нэгтгэгдсэнээр сонирхлын зөрчлийн эрсдэлийг үүсгэх ба эрсдэлийг удирдах болон бусад хяналтын тогтолцооны зарчмуудад харшилдаг.

Байгууллагын хяналтын тогтолцоонууд нь чиг үүргийнхээ хувьд ялгаатай байгаа шиг хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь цаг хугацааны хувьд ч мөн адил өөр байдаг.

Жишээлбэл:

Дотоод хяналт: Удирдлага болон ажилтан өөрийн хариуцсан чиг үүргээ гүйцэтгэж байх одоо цагийн үйл явцад хяналт тавьдаг.


Комплайнс: Эрсдэлийг удирдах үүрэг бүхий комплайнсын хяналт нь байгууллагын бүх шатанд үүсэж болзошгүй комплайнсын эрсдэлийг тооцон уялдуулснаар цаг хугацааны хувьд урьдчилсан төлөвтэй ажилладаг.

Дотоод аудит: Олон улсын стандартад зааснаар дотоод аудитыг аль болох эрсдэлд суурилсан байдлаар хийх шаардлагыг тавьж байгаа хэдий ч практикт ихэвчлэн алдаа дутагдал, зөрчил гарсны дараагаар аудит

хийгдэж, дотоод хяналтын аль процесст алдаа гарсныг илрүүлж, залруулах талаар зөвлөмж хүргүүлдэг.

Үүнээс үзэхэд хяналтууд нь өөр хоорондоо чиг үүргийн болон хэрэгжүүлэх цаг хугацааны хувьд ялгаатай байдаг тул дотоод хяналт, комплайнс болон дотоод аудитын үйл ажиллагааг нэг нэгжээр гүйцэтгүүлэх нь зохимжгүй юм.

Байгууллагын үйл ажиллагааны хамгаалалтын буюу эрсдэлийг удирдах 3 үе шат гэж байдаг. Дотоод хяналт, комплайнс болон дотоод аудит нь эдгээр үе шатанд хуваагдаж хяналтын чиг үүргүүдээ гүйцэтгэж байдаг. Үүнийг зураглалаар үзүүлбэл илүү ойлгомжтой харагдана.



Дээрх зураглалаас харахад дотоод хяналт, комплайнсын хяналт нь байгууллагын гүйцэтгэх удирдлагад үйл ажиллагаагаа шууд тайлагнаж байгаа боловч комплайнсын хяналтын хувьд дотоод аудитын адил үйл ажиллагаагаа байгууллагын дээд шатны удирдлага буюу төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах суваг нээлттэй байх боломжтойгоороо дотоод хяналтаасаа ялгаатай байдаг.

Комплайнсын хяналтыг амжилттай хэрэгжүүлэх нь:

Байгууллагадаа комплайнсын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд комплайнсын нэгж / ажилтан нь холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг судалж, байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх комплайнсын хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй.

Ингэснээр байгууллагын комплайнсын үйл ажиллагаа албажих бөгөөд хууль тогтоомж, дүрэм журам, стандартуудыг дагаж

мөрдөхөд чиглэсэн байгууллагын дотоод бодлого, журмыг багцалж, илүү тодорхой, ойлгомжтой болгох нөхцөл бүрддэг.

Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг гурван түвшинд хуваадаг. Үүнд:

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ	ИЛРҮҮЛЭХ	ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ
Комплайнсын эрсдэлийг үнэлэх	Мэдээлэл солилцох, тайлагнах суваг	Алдаандаа дүгнэлт хийх
Бодлого, дүрэм журам, аргачлал боловсруулах	Хяналт/аудитын тайлан	Залруулах, эрх зүйн сайжруулалт хийх
Комплайнсын ажилтан томилох	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх	Мэдээллийг ил тод тайлагнах,
Сургалт явуулах		Сурталчлан таниулах

Аливаа байгууллага үйл ажиллагааныхаа зорилго, онцлогоос хамаарч тусгайлсан өөр өөр төрлийн бодлогын баримт

бичиг, дүрэм журам, стандарт, аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх замаар өөрийн гэсэн комплайнсын системийг бий болгох боломжтой.

Комплайнсын нэгж/ажилтан нь хууль, эрх зүйн шинэчлэлийг тухай бүр олж мэдэн байгууллагын дотоод үйл ажиллагаандаа дагаж мөрдөх комплайнсын хөтөлбөрт багтаах бодлого, дүрэм журам, аргачлалаа шинэчлэн боловсруулж байх хэрэгтэй.

Комплайнсын хөтөлбөрт дараах бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, тэдгээрт нийцүүлэн дүрэм журам, аргачлалуудыг багтааж болно. Жишээ нь:

Ёс зүйн хэм хэмжээ: Ажилтнуудын ёс зүй, биеэ авч явах хэм хэмжээ болон үүрэг

хариуцлагыг тодорхойлж, үндсэн зарчмуудыг тусгах;

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх: Хууль бус орлогыг санхүүгийн салбарт оруулан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, дотоод журам боловсруулах;

Бэлэг хүлээн авах, бэлэглэх: Бэлэг, авлига, албан тушаалаа урвуулан ашиглаж ашиг олохтой холбоотой асуудал зэргийг нарийвчлан тогтоох /Тухайлбал бэлэг авах үйлдэлд бүхэлд нь хориг тавих бус түүний үнэ өртөгт хязгаар тавих, бэлэглэх, бэлэг хүлээн авах үйл явцыг дотоод журмаар зохицуулах/;

Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөнийг мэдээлэх: Ажилтнуудын гаргасан ёс зүйн зөрчлийн

талаар мэдээлэл авах, баримтжуулах, мэдээлэгчийн нууцыг хадгалах;

Сонирхлын зөрчлийг зохицуулах: Сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд байгууллагын ажилтнуудын авч хэрэгжүүлэх ёс зүйн арга хэмжээний аргачлал боловсруулах;

Ажилтан үнэт цаас худалдан авах: Санхүүгийн байгууллагын ажилтнууд үнэт цаасны зах зээлд оролцох үед баримтлан хэрэгжүүлэх хэм хэмжээг тогтоох;

Мэдээллийн тусгаарлалт /цагаан хэрэм/: Мэдээллийн хана буюу дотоод мэдээллийн нууцлал, хадгалалтын байдлыг сайжруулах;

Мэдээллийн нууцлал: Харилцагч болон түүний хэлцлийн талаарх мэдээллийг нууцлах хяналтыг бий болгох.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ





Үнэт цаасны зах зээлд нийт **526**

зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна.

Арилжаа эрхлэх 2	Төлбөр тооцоо 1	Төвлөрсөн хадгаламжийн 1
ХОМК 24	Арилжаа эрхлэгчдийн холбоо 1	Кастодиан 3
Андерайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 4	ХК 306
ҮЦК 54	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 13
ҮЦ33-д аудитын үйлчилгээ үзүүлэх 59	ҮЦ33-д үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 23	ҮЦ33-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 32

*ҮЦК-д брокер, дилер, андерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.




Үнэт цаасны зах зээлийн арилжаа

- Нийт арилжааны хэмжээ өмнөх оноос **41.5 хувиар** буурав.
- Үүнд ЗГҮЦ-ны ажилжаа 71.1 хувиар, компанийн бондын арилжаа 88.2 хувиар, хувьцааны арилжаа 36.4 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.
- 2019 онд нийт 4 компани **42.5 тэрбум төгрөгийн IPO** хийсэн бол ЗГҮЦ-ны болон компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаа идэвхгүй байв.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх онтой харьцуулахад **7.2 хувиар** өссөн бол хөрвөх чадвар **3.4** пунктээр буурлаа.
- Хөрвөх чадвар буурахад хувьцааны арилжааны хэмжээ буурсан нь голчлон нөлөө үзүүлээ. Хувьцааны арилжааны хэмжээ 2018 онд хэт өндөр байсан нь Лэндмн ББСБ, Дархан нэхий, МЦХ, Мик холдинг, АПУ зэрэг ХК-уудын багцын арилжаа хийгдсэнтэй холбоотой.




Үнэт цаасны зах зээлийн индекс

- **ТОП-20 Индекс** өмнөх онтой харьцуулахад **1,844.9** нэгжээр буюу 8.6 хувиар буурсан.
- **MSE A** индекс 2018 оноос **73.2** нэгжээр буюу 0.8 хувиар өссөн.
- **MSE Б** индекс 2018 оноос **371.3** нэгжээр буюу 4.5 хувиар буурсан.



ХАА-н биржээр нийт 705.1 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 6.4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд үүнд хонины ноос болон ямааны завод ноосны арилжааны хэмжээ буурсан нь голчлон нөлөөлжээ.



ХАА-н биржийн MAPIX индекс



ХАА-н биржээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу **MAPIX** 2019 оны байдлаар **794,316.1** нэгжид хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 67,104.4 нэгжээр буурсан байна.

1.2 ДААТГАЛЫН САЛБАР




ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2019 онд даатгалын гүнзгийрэлт 0.56 хувьд хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.




* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Тайлант онд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 10.2 хувиар өсөж, өмнөх улирлаас 2.1 хувиар буурч 365.8 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад 11.2 хувиар өсөж 281.2 тэрбум төгрөг хүрч, салбарын нийт хөрөнгийн 76.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 7.5 хувиар өсөж 75.4 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 20.6 хувийг эзэлж байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 4.2 хувиар өсөж 9.2 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 2.5 хувийг эзэлж байна.

- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2019 онд нийт 196.6 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 195.3 тэрбум төгрөг буюу 99.4 хувь, урт хугацааны даатгалын компани 1.3 тэрбум төгрөг буюу 0.6 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 57.3 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 2.1 тэрбум төгрөг буюу 3.7 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2019 онд ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх онтой харьцуулахад 11.1 хувиар өсчээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2019 онд 65.5 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 13.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.2 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 11.3 хувиар өсөж 11.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.




1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

- Тайлант онд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр 538 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Эдгээрийн 74 буюу 13.8 хувь нь орон нутагт, 464 буюу 86.2 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.2 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай, 94.8 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.

5.2%
Гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага




2.9 сая
Банк бус санхүүгийн байгууллагын харилцагчдын тоо

538
Банк бус санхүүгийн байгууллага



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2019 онд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 445.2 тэрбум төгрөгөөр буюу 34.7 хувиар өсчээ.




81.7%
Зээлийн өсөлтийн нөлөө

34.7%
Хөрөнгийн өсөлт

63.7%
ХНХ-ийн өсөлтийн нөлөө






НИЙТ ЗЭЭЛ

2019 оны байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 41.9 хувиар буюу 363.9 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Зээлийн хүү: 2019 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.0 хувьд хүрч буурлаа.

2019 оны байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 98.2 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 1.8 хувийг валютаар олгосон зээл эзэлж байна.

98.2%



1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2019 оны байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо 261-т хүрч өмнөх оноос 6.5 хувиар буурлаа.
- ХЗХ-ны гишүүдийн тоо өнгөрсөн онд 62,556 байсан бол тайлант онд 13.4 хувиар өсөж 70,968-д хүрчээ.



АЖИЛЛАГСАД

811

ХЗХ-дын нийт ажиллагсдын тоо өнгөрсөн оноос 1.9 хувиар нэмэгдсэн бөгөөд түүний 73.4 хувь нь эмэгтэй

НИЙТ ГИШҮҮДИЙН


36,278

ЗЭЭЛДЭГЧ

36,483


ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ ○ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/



НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Тайлант онд нийт хөрөнгө өмнөх оноос 11.2 хувиар өсөж 222.6 тэрбум төгрөгт хүрчээ.
- Хөрөнгийн өсөлт өмнөх оноос 19.5 пунктээр буурчээ.



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

КОВИД–19 БА ДААТГАЛЫН САЛБАР

Дэлхийн нийтийг хамарсан КОВИД–19 цар тахлын улмаас Олон улсын нийгэм, эдийн засагт хямрал үүсээд байгаа билээ. Энэхүү хямралын нөлөөлөл нь даатгалын салбарыг ч мөн адил дайран өнгөрч байгаа хэдий ч улс орнууд тус давалгааг даван туулахын тулд тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Иймд уг цар тахлын хор хөнөөл Олон улсын хийгээд Монгол Улсын даатгалын зах зээлд хэрхэн нөлөөлж буй талаар мэдээллийг бэлтгэлээ. Тухайлбал:

Япон Улс: Японы даатгалын компаниудад учирч болох томоохон эрсдэл нь хөрөнгө оруулалтын эрсдэл байна гэж үзжээ. Үүнд валютын эрсдэл, хөрөнгө болон өр төлбөрийн менежментийн эрсдэл орж байна. Мөн Засгийн газрын бондын хүү буурснаар Японы амьдралын даатгалын компаниудын хөрөнгийн өгөөж буурах таамагтай байна.

Даатгалын компаниудын эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөр бага байна гэж тооцролж байгаа бөгөөд учир нь КОВИД–19–тэй холбоотой бүх эмнэлгийн зардлыг Японы Засгийн газар хариуцахаар зохицуулсан.

Одоогийн байдлаар Япон улс өвчилсөн хүний тоогоор 23–т орж байгаа ч нас барсан хүний тоо маш бага байгаа тул амьдралын даатгалын компаниудын хувьд ч эрсдэл бага гарахаар байна. Энэ нь Японы эрүүл мэндийн систем сайн ажиллаж байгаатай холбоотой тул цаашид ч нас баралт бага байх таамагтай юм. Тиймээс эрүүл мэндийн даатгал болон амьдралын даатгалаар даатгалын компаниуд өндөр эрсдэл хүлээхгүй гэж “Fitch ratings” үзэж байна.

Дэлхийн эдийн засгийн уналттай холбоотой олон компаниудын үйл ажиллагаа доголдож эхлээд байгаа тул цаашид Япон улсын ердийн даатгагч нарын хувьд бизнес тасалдлын даатгалын эрсдэл өндөр гарах магадлалтай байна.

Хонгконг: Хонгконгийн томоохон даатгалын компаниудын төлөөлөгчдөөс бүрдсэн багийн хийсэн дүгнэлтээр КОВИД–19–ийн тархалтын улмаас Хятадын жуулчдаас орж ирдэг даатгалын хураамжийн орлогын хэмжээ огцом буурсан бөгөөд өмнөх оны 01 дүгээр сард даатгалын хураамжийн орлого 644.0 мянган ам.доллар байсан бол энэ оны 01 дүгээр сард 12.8 мянган ам.доллар хүртэл буурчээ.

Үүнээс хамаарч 01 дүгээр сарын 20–ны өдрөөс 4 дүгээр сарын 20–ны өдрийг хүртэл Хонгконгийн бирж дээр бүртгэлтэй даатгалын томоохон компаниуд болох “AIA” компанийн хувьцаа 18.1 хувиар, “Prudential” компанийн хувьцаа 31.5 хувиар, Хятадын “Ping An” компанийн хувьцаа 20.9 хувиар, “New china life” компанийн хувьцаа 28.4 хувиар, “China pacific” компанийн хувьцаа 20.5 хувиар тус тус буурсан байна.

Хонгконг, Сингапур зэрэг улсад “Prudential” даатгалын компани КОВИД–19 тахлын эрсдэлээс хамгаалж 1.5 сая сингапур долларын

санг бүрдүүлж, үйлчлүүлэгчидээ дэмжин ажиллаж байна. Мөн Сингапурын AIA даатгалын компани 1.4 сая үйлчлүүлэгчидээ үнэгүй даатгалын үйлчилгээг санал болгосон. Энэ даатгалын гэрээгээр КОВИД–19 өвчнөөр өвчилсөн бол 1000 хүртэлх долларын нөхөн төлбөр олгохоор шийдсэн байна.

Монгол Улс: КОВИД–19 цар тахлын тархалтын улмаас Улсын онцгой комиссоос 2020 оны 1 дүгээр сарын 31–ний өдрөөс 4 дүгээр сарын 30–ныг дуустал хэсэгчилсэн болон бүрэн хөл хорио тогтоосон нь бизнесийн салбаруудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй нь даатгалын салбарт шууд хамааралтай байхаар байна. Иргэд, байгууллагын хувьд даатгал нь хэмнэж болохоор зардал болоод байгаа бөгөөд гадаад зорчигчдын амь нас, эрүүл мэндийн даатгал, ачааны даатгал, малын индексжүүлсэн даатгал, жолоочийн хариуцлагын даатгалын бүтээгдэхүүнүүдийн борлуулалт зогсож, даатгалын компаниудын орлого буураад байгаа юм.

Иймд даатгалын салбарт үүсээд буй хүндрэлийг даван туулахын тулд Санхүүгийн зохицуулах хорооноос нөхцөл байдлыг судлан үзэж, холбогдох хүчин зүйлсийг харгалзан, үндсэн 8 чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, даатгалын холбоо болон даатгагч нартай хамтран хэрэгжүүлж байна. Тухайлбал иргэдэд даатгалын ач холбогдлыг таниулах чиглэлээр гадаадад зорчигчдын амь нас, эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүний ач холбогдол, эрсдэлийн хамгаалалт, нөхөн төлбөр олгох нөхцөлд КОВИД–19–ээр өвчилсөн тохиолдолд хамгаалах эсэх талаар заавар, зөвлөмж, мэдээллийг Хорооны болон уг бүтээгдэхүүнийг борлуулдаг даатгагч нарын цахим хуудсанд байршуулсан.

Мөн КОВИД–19 болон томуу, томуу төст өвчний эрсдэлээс хамгаалах даатгалын шинэ бүтээгдэхүүн зах зээлд гаргах талаар санаачлага гарган ажиллах чиглэлээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд халдварын өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй улсын эмнэлгийн ажилтнууд, онцгой байдлын албан хаагчид болон төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүйгээр даатгах “КОВИД–19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”–ын бүтээгдэхүүнийг гаргаж Хороонд бүртгүүлэх хүсэлтээ ирүүлсэн. Хорооны зүгээс цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан түргэн шуурхай ажиллаж, вирусийн тархалтыг тогтоон барихаар өвчний голомт дээр ажиллаж буй төрийн албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүй даатгаж байгааг дэмжиж, Хорооны хуралдаанаар хэлэлцэн “КОВИД–19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”–ын бүтээгдэхүүнийг бүртгэлээ.


“Ковид–19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”–д Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 13.1.6–д заасан төрийн тусгай албан хаагчид, Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.5–д заасан эмнэлгийн мэргэжилтнүүд, мөн хуулийн 3.1.6–д заасан эрүүл мэндийн нийт ажилтнууд үнэ төлбөргүй хамрагдах боломжтой билээ.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

S&P 500 /^GSPC/

2,878.48 +41.74 (+1.47%)




Nikkei 225 /^N225/

19,721.36 -61.86 (-0.31%)



FTSE 100 /^FTSE/


5,846.79 +94.56 (+1.64%)




Dubai Financial Market General Index DFMGI:IND

1,986.09 +29.41 /+1.50%/



 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

 +976-51-264444

 press@frc.mn

 www.frc.mn

 Санхүүгийн зохицуулах хороо

 @FRC_of_Mongolia